

Mongolian Economy

2026 ОНЫ 04 САР (203)

www.mongolianeconomy.mn

Онцлох нийтлэл

Шинэ жарны босгон дээрх
МҮХАҮТ

Бизнесийн орчин

“Чөдөртэй морь”-оо чөлөөлье



"Номин Холдинг" ХХК-ийн
Зөвлөх, Монгол Улсын
Худалдааны гавьяат ажилтан

А.ШАГДАРСҮРЭН

**ЦАГ ХУГАЦААГ
ХОЖИЖ ЧАДСАН**

Хүн

АНУН

АЖИЛ ГЭР, АЗ ЖАРГАЛ

Бид орчин үеийн чиг хандлагыг баримтлан ажил болон гэрийн орон зайг дэлхийн жишигт нийцсэн дизайн бүхий монгол хүний биеийн онцлог, эргономик бөгөөд тав тухыг дээд зэргээр хангах импортын болон үйлдвэрийн бүтээгдэхүүнийг санал болгож 29 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тохижуулсан талбай

36 ШИРХЭГ CENTRAL TOWER-ТЭЙ ТЭНЦЭНЭ.

Борлуулалт

1 ЖИЛД БОРЛУУЛДАГ ТОО



7219

Сандал



4176

Ширээ



ОНЦЛОХ БРЭНД

FURSUS

FURSUS бол ажлын орчныг сайжруулахын тулд түүхий сайн чанарын бүтээгдэхүүн оффис шийдлүүдийг санал болгодог дэлхийд тэргүүлэгч компанийн нэг юм. Орчин үеийн загварлаг ашиглалт сайтай өнгөлөг. FURSUS брэндийн оффис тавилгууд нь цөөхөн хийцлэлдээ анхаарах бус шалтгааныг дээд зэргээр хангаснаараа онцлогтой.





05 РЕДАКЦИЙН ЗУРВАС

Бизнесийн “АКУЛ”-ууд нэг дугаарт

06 ОНЦЛОХ ЗОЧИН

Цаг хугацааг хожиж чадсан хүн

14 ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

Шинэ жарны босгон дээрх “танхим”

18 ЗОЧИН

УИХ ажлаа хийж чадвал энэ хавар “реформын хавар” болно

24 ТАНХИМ 5.0

Шинэ үеийн танхим

26 БИЗНЕСИЙН ОРЧИН

“Чөдөртэй морь”-оо чөлөөлье

28 БАЯЛАГ БҮТЭЭГЧИД

“Хүнсний хувьсгал”-ын үр дүнд 53 үйлдвэр ашиглалтад оров

30 ОРОН НУТАГ

Хязгаарлагдмал хүртээмжийг тэлэх стратеги

36 БАДРАХ ЭНЕРЖИ

Зөөвч-Овоо төсөл Монголын уул уурхайн салбарт технологийн дэвшил авчирна

40 ОРХОН

Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг шинэчлэх шаардлагатай

42 ХӨВСГӨЛ

Шинэ технологи нутагшуулж, хиймэл оюун ухааныг нэвтрүүлсэн бүс болно

44 МОНГОЛЧУУД ГАДААДАД

Хилийн чанадад буй иргэдэд хандсан төрийн бодлого хэрэгтэй байна





БИЗНЕСИЙН “АКУЛ”- УУД НЭГ ДУГААРТ

1990-ээд оны дунд үеийн хүндхэн, юм хум ховор живэр үед Улаанбаатарын бүхий л зүйл “бараан” мэт санагддаг байлаа. Харин гадаадын төрөл бүрийн брэндийн цахилгаан бараанууд зарагдаж эхэлсэн нь монголчуудын амьдралд нэгэн “өнгө нэмсэн” билээ. “Mongolian Economy” сэтгүүлийн энэ дугаарын зочин, “Номин Холдинг” ХХК-ийн зөвлөх, Худалдааны гавьяат ажилтан А.Шагдарсүрэн тэрхүү цаг үеийн талаар “Номингийн хамт олны бизнесийг зөвхөн арилжаа наймаа төдий бус монголчуудын ахуйн хэрэглээний соёлд хувьсгал хийсэн чухал үйл явдал гэж үзэж болно. Япон, Сингапур зэрэг улсын электрон барааны шилдэг брэндүүдийн ачаар тухайн цаг үед монголчууд гар угаалга, нидрүүлгээс угаалгын машин, дэрсэн шүүрнээс тоос сорогч, өртөө шуудангаас гар утас, махны шууз, борцноос хөлдөөгч, радионоос өнгөт телевизортой болж томоохон шилжилт хийсэн” гэж дурдсан юм. А.Шагдарсүрэн гуайг монголчууд “Номин”-гийн хэмээн хүндэлдэг. Бүтээн байгуулсан зүйлээрээ овоглуулж, олондоо хүндлүүлэх шиг эрхэм хүндлэл энэ хорвоод үгүй. Гэвчиг А.Шагдарсүрэн гуайг зөвхөн “Номин”-гийн гэж авгайлах нь нэг талаар өрөөсгөл юм. Түүний туулж өнгөрүүлсэн 85 жилийн намтар түүхийг судлан сонирхвол өөр олон дүр тодорно. Монголын бизнесийн салбарын

нэгэн томоохон аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагчийн хөрөг нийтлэлээс гадна бизнесийн төлөөллийн гол байгууллага болох Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай багц контентыг бид энэ дугаартаа багтаалаа. МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч, гавьяат эдийн засагч Б.Лхагважавтай бизнесийн орчинд гэрэл асаах найдвар тээсэн Нийгмийн даатгал болон Татварын багц хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Арилжааны хууль, Танхимын хууль, Зээлийн хүүд хязгаар тогтоох тухай зэрэг хуулиудын талаар ярилцсан. Мөн МҮХАҮТ-ийн ирэх 60 жилийн хөгжлийн төлөв, “Танхим 5.0” концепц, 2026 оныг “Бодлогын өмгөөллийн жил” болгон зарласных нь ач холбогдол зэрэг мэдээллийг уншаарай. Гадаадын хөрөнгө оруулалтын сайн жишээ болж, Монгол Улсын уул уурхайн салбарт шинэлэг ашигт малтмал, стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүнийг олборлож буй том амбицтай хамт олон бол “Бадрах Энержи” компани. Тус компанийн ерөнхий захирал, Франц Улсын иргэн К.Принтэй бид Зөөвч-Овоо төслийн талаар ярилцсан юм. Хатагтай К.Прин өнгөрсөн оны намар Монголд ирснээсээ хойш хэвлэл мэдээлэлд анх удаа ийм дэлгэрэнгүй ярилцлага өгч байгааг дурдъя. ■

Эрүүл сэтгүүл зүй

Mongolian¹⁵
Economy

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр (9999 4248)

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

Н.Энхбаяр (9916 1303)

РЕДАКТОР:

Т.Амаржаргал

АНГЛИ РЕДАКТОР:

Роберт Йохан Шрайверс

СЭПҮҮЛЧИД:

У.Сарангэрэл

Б.Шүрэнчимэг

Р.Ренчиндулам

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

Б.Тэргэл

БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗАР

7011-1125 | 99971391

7011-1126 | 99971392

20||-2026

ISSN 2664-195X

E-MAIL: info@mongolianeconomy.mn

FACEBOOK: Mongolian Economy

TWITTER: EconomyMongolia

А.Шагдарсүрэн

"Номин Холдинг" ХХК-ийн Зөвлөх,
Монгол Улсын Худалдааны гавьяат ажилтан

ЦАГ ХУГАЦААГ ХОЖИЖ ЧАДСАН

Хүн



Амарбаярын Шагдарсүрэн гуайг монголчууд “Номин”-гийн хэмээн хүндэлдэг. Бүтээн байгуулсан зүйлээрээ овоглуулж, олондоо хүндлүүлэх шиг эрхэм хүндлэл энэ хорвоод үгүй. Гэвчиг А.Шагдарсүрэн гуайг зөвхөн “Номин”-гийн гэж авгайлах нь нэг талаар өрөөсгөл юм. Түүний туулж өнгөрүүлсэн 85 жилийн намтар түүхийг судлан сонирхвол өөр олон дүр тодорно. Тэдгээрийн тухай энэхүү нийтлэлдээ өгүүлэх болно.

Торгууд нутгийн хөвгүүн

Торгууд түмний их нүүдлийн тухай сонсоогүй, нулимс унагаагүй монгол хүн ховор биз ээ. Тэртээ 1630 онд 250 мянга орчим ойрад монголчууд одоогийн ОХУ-ын Ижил мөрний үржил шимтэй газарт нүүдэллэн иржээ. Гэвч тэд 140 жилийн дараа дахин их аянд гарч 4800 км замыг туулсаар Монгол нутагтаа ирсэн байна. Нүүдлийн замд 100 мянга орчим торгууд хүн зуур замын тулаан, өвчин зэрэгт амь үрэгдсээр, ердөө 20 мянган өрх буюу 70 орчим мянган хүн Зүүн гар, Бор тал, Минжит Булган, Мэргэн Байтагийн ууландаа ирсэн гэдэг.

Ард олны дунд торгуудын баруун хошууг вангийн, зүүн хошууг бэйсийн гэж засаг ноёных нь хэргэмээр нэрлэж байсан агаад вангийнхан дотор хонгараачин овогтнууд байсан. А.Шагдарсүрэн гуайн аав Амарбаяр чухам тэр овгийн хүн юм.

А.Шагдарсүрэн 1941 оны тавдугаар сарын 1-нд Ховд аймгийн Булган сумын Шар хулсны Зэл мод гэдэг газар эгэл малчин Амарбаярын отгон хүү болон мэндэлжээ. Тухайн үед Монгол Улсын Баруун хязгаарын байдал нэн төвөгтэй, бүр дайны ирмэгт тулсан хүнд үе байлаа. Асар их бэрхшээл зовлон, дээрэм тонуулын дунд амьдарч, сэтгэл санааны хүнд үеийг гэр бүлээрээ даван туулсан тухай А.Шагдарсүрэн гуай дурссан байдаг. Аав Амарбаяр, ээж Б.Түвшээ нь хүүхдүүдээ аваад бусдын адил ууланд бүгэж, нутаг дамжин явж байжээ.

“Багадаа ээжтэйгээ хонь, хурга хариулж, малын түүхий эд боловсруулж байсан. Аавтайгаа газар хагалж, тариа тарьж, андисны морь, тэмээ хөтөлж, хөц цохиж, айраг бүлж, мод түлээ түүж, ус мөс зөөж байсан дурсамж ер санаанаас гардаггүй

юм” хэмээн А.Шагдарсүрэн гуай “Далдугаар зөрлөг” номдоо бичсэн байдаг.

Ах А.Пагма, эгч А.Цэвэг нь түүнээс олон насаар ах байсан учир тэднээсээ суралцдаг, том болоод ах эгч шигээ хүн болохыг мөрөөддөг байжээ. Түүний ах А.Пагма Баруун Монголоос төрсөн анхны хүний их эмч, Ховд аймгийн шилдэг 100 эрхмийн нэг, эх барих эмэгтэйчүүдийн эмчээр хот, хөдөөгийн эмнэлгүүдэд насаараа ажиллаж бусдын сайн сайхны төлөө амьдралаа зориулсан нэгэн юм.

Сонирхуулахад, БНМАУ-ын баатар Э.Шийлэг бол А.Шагдарсүрэнгийн авга ах. Гоминданы цэрэг, Оспаны дээрэмчид Баруун хязгаарт үймээн дэгдээж, халдлага үйлдэж байхад Э.Шийлэг хилийн цэрэгт туслах ардын группийн хамгийн туршлагатай пулемётчин, ахлагчийн үүрэг гүйцэтгэж олон удаагийн тулгаралт, байлдаанд оролцон эрэлхгээр тулалдаж байсан аж. Мөн Халхын голын дайнд эхнээс нь дуустал оролцож байсан баатарлаг намтартай хүн. Түүний энэ гавьяаг үнэлж, Халхын голын байлдааны 45 жилийн ойг тохиолдуулан 1984 онд БНМАУ-ын баатар цолоор шагнасан юм. “Ахынхаа тухай, ер нь энэ дайнд оролцсон олон арван “баатар цол” хүртээгүй хүмүүсийн тухай бичихгүй бол тэр он жилүүдийн тухай мэдэх хүмүүс энэ цаг мөчид надаар л өндөрлөх гээд байна. Ер нь хоёулаа хамтарч баримтат кино хийвэл ямар вэ” хэмээн А.Шагдарсүрэн гуай санал тавьж, хамтдаа “БНМАУ-ын баатар торгууд нутгийн хөвгүүн” уран бүтээлээ эхлүүлж байсан талаар Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Нагнайдорж дурссан нь бий.

Төрөлх нутаг, торгууд түмнийхээ төлөө А.Шагдарсүрэн гуай үргэлж нэгийг сэдэж, хоёрыг хийж байдаг хүн. 2014 онд Булган сумандаа БНМАУ-ын баатар Б.Бадам, Э.Шийлэг нарын хөшөөг босгож, үндэсний бөхийн дэвжээ байгуулж өгснөөс гадна ах А.Пагмынхаа нэрэмжит өрхийн эрүүл мэндийн төвийг барьж бэлэглэсэн, аймгийнхаа төвд анхны агуулах худалдааны дэлгүүр, дараа нь худалдааны төв барьсан зэргийг дурдаж болно.

Торгууд түмэн хэдий цөөхөн боловч олон алдартан, гавьяатныг төрүүлсэн. Монгол Улсын баатар хоёр, хөдөлмөрийн баатар ес, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн 18, Ардын болон гавьяат цолтон 60 гаруй бий. Тэдгээр гавьяатуудын нэг нь “Номин Холдинг” ХХК-ийн зөвлөх, Монгол Улсын Худалдааны гавьяат ажилтан А.Шагдарсүрэн билээ.

Монголчууд ажлын таван өдөртэй, зүй нь ажлын зургаан өдөртэй ажиллах ёстой. Япон, Солонгос, Хонконг зэрэг улс яаж хөгжсөн гэвэл юун амрах тухай ойлголт, тэд чинь амралтгүй, хоол ундаа хасаж зүтгэн байж энэ хэмжээнд хүрсэн юм



Төрөлх нутаг, торгууд түмнийхээ төлөө А.Шагдарсүрэн гуай үргэлж нэгийг сэдэж, хоёрыг хийж байдаг хүн

Цаг хугацааг хожих чин хүсэл

“Би 1970-аад оны үед “Цаг хугацааны үнэ цэн” сэдвээр лекц бичиж үйлдвэр, аж ахуйн газрын ажилчин, албан хаагчдад яриа хийдэг байж билээ. Хоногийн 24 цагийг хэрхэн ашиглах вэ гэдэг асуудал бүх хүнд хамаардаг учир их сонирхолтой сэдэв юм. “Өнгөрсөн минут эргэж ирдэггүй” гэж бид сурагч байхаасаа ярьдаг болчихсон хэдий ч түүнийг яаж зөв зохистой ашиглах талаар тэр бүр хэвшил болгож дадаагүй. Цагийг хожвол бүхнийг хожно” хэмээн А.Шагдарсүрэн гуай өгүүлэв.

Амьдралынхаа энэ зарчмыг тэрбээр олон хүнд хүргэхийг хичээсээр буй. Түүний 2008 онд үүсгэн байгуулсан “Монгол тэмүүлэл Сайхан Монгол орон” ТББ их, дээд сургуулиудад тодорхой сэдвээр долоо хоногийн аян өрнүүлж, энэ үеэрээ нэр хүндтэй, олонд

хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээр яриа, лекц хийлгэдэг уламжлалтай байв. Тэдгээрийн нэг нь “Эртэч монгол хүн” арга хэмжээ юм. Тэрбээр “өнөөдрийн залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчныг нь маш сайн бүрдүүлэх хэрэгтэй” хэмээн онцолсон.

“Монголчууд ажлын таван өдөртэй, зүй нь ажлын зургаан өдөртэй ажиллах ёстой. Япон, Солонгос, Хонконг зэрэг улс яаж хөгжсөн гэвэл юун амрах тухай ойлголт, тэд чинь амралтгүй, хоол ундаа хасаж зүтгэн байж энэ хэмжээнд хүрсэн юм” гэж 2018 онд өгсөн нэгэн ярилцлагадаа дурдсан нь хувь хүний болоод улс орны хөгжил мөн цаг хугацааны талаарх түүний гол философи болов уу.

Түүний хувьд цаг хугацааг эрхэмлэж, цаг үргэлж үр бүтээлтэй ашигласаар ирснийг нь харуулах нэг тод баримт бол 20 гаруй жилийн турш өдрийн тэмдэглэл хөтөлж буй тууштай зан нь юм. Түүнээс гадна А.Шагдарсүрэн гуай 1980-аад оноос бичиг цаас нийлүүлэн уран бүтээлийн гараагаа эхлүүлж, 20 гаруй ном хэвлүүлж, олон арван дуу, шүлэг, найраглал, аян замын тэмдэглэл туурвижээ. Улс төр, эдийн засаг, түүх, соёл, яруу найргийн зэрэг олон сэдвийн бүтээлүүд түүнд бий. Тэдэн дунд “Торгууд ардын аман зохиол”, “Зүйр цэцэн үгсийн хоймсон хураангуй”, “Баруун Монгол ардын дуу хөгжим”, “Ойрад ардын холбоо үг аялгын тайлал”, “Торгуудын түүхэн товчоон” зэрэг нутаг устай нь холбоотой бүтээлүүд олон байдаг. Мөн “Номин Холдинг” компани, Монгол хүний зорилго, тэмүүлэл, ардын уламжлалын талаарх ном зохиол ч арвин бий. А.Шагдарсүрэн гуай өөрөө бичиж туурвиад зогсохгүй олон зохиолч, яруу найрагч, кино найруулагч, уран бүтээлчдийн 50 орчим ном туурвилыг ивээн тэтгэжээ.

“Номин Холдинг” компани ч олон арван оюуны бүтээлийг эрхлэн гаргаж, ивээн тэтгэж, хамтран ажиллаж байсан нь үүсгэн байгуулагчдын хүсэл сонирхол, зорилготой холбоотой. Тухайлбал, “Монголын 100 хаан” 11 боть, “Найман богд” хоёр цуврал бүтээл, Төрт ёс Хаадын сангаас гаргасан цуврал ботиуд, Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингэс хаан, Чингэс хааны нэвтэрхий толь, “Улирал ба Зохиолч” улирал тутмын сэтгүүл зэрэг 40 орчим бүтээлийг ивээн тэтгэжээ.

Бийр янтай нийлүүлэхээс гадна эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу үндэсний барилгын салбарын хөгжилд, Улаанбаатар хотын бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, одоогийн хэллэгээр бол томоохон төслүүдэд гар бие оролцож байсныг нь дурдалгүй өнгөрч боломгүй. ▶

▶ А.Шагдарсүрэн гуай 1964 онд МУИС-ийг барилгын инженер мэргэжлээр суралцаж төгсөөд Улаанбаатар хотын Байшин үйлдвэрлэх комбинатын хөвөнгийн заводод техникчээр ажиллаж эхэлжээ. Ганц сар техникч хийгээд комбинатынхаа ерөнхий инженерээр дэвшин ажилласнаас хойш бүтээн байгуулалт, удирдлагын ажилд ханцуй шамлан оров. Түүний гар бие оролцсон бүтээн байгуулалтын тоонд одоогийн “Атар-Өргөө” ХК-ийн барилга, 15-р хорооллын угсармал орон сууцны барилгууд, 100 автобусны зогсоол, Холбооны яам, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Монгол кино үйлдвэр, ШУА-ийн хими, физик, түүхийн хүрээлэн, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн өргөтгөл, МҮЭ-ийн соёлын төв ордон зэрэг томоохон барилга байгууламж багтдаг.

Мэдээж түүний цаг хугацаа, хүч хөдөлмөрөө хамгийн их зориулсан “бүтээн байгуулалт” нь өнөөгийн “Номин холдинг” компани билээ.

“Номин”-гийн А.Шагдарсүрэн

Дөрвөн жилийн өмнө АСЕМ Виллад болсон “Номин Холдинг” компанийн 30 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох завшаан сэтгүүлч надад тохиосон юм. Гадаадын олон арван брэндийн төлөөлөл болсон түмэн хүн мянган хэлээр хэлэлцэн, өмнөх болон ирээдүйн хамтын ажиллагаагаа ярилцан, үр ашигтай бизнесийн түншлэлээ хүндлэн байхыг хараад “Номин”-гийн хамт олныг үнэхээр л дэлхийн хэмжээнд ажилладаг компани гэдгийг ойлгосон юм.

Санхүүгийн бат бөх байр суурь, бизнесийн томоохон платформ, удирдлагын ёс зүйтэй бөгөөд итгэл даах харилцааг нь “Номин”-гийн гол давуу тал гэж үзэн олон жилийн турш хамтран ажиллахдаа таатай байдгийг энэ үеэр гаднын олон түнш нь илэрхийлж байлаа. Тухайлбал, монголчуудын сайн танил Terranova, Calliope брэндийг үйлдвэрлэгч Италийн TEDDY группийн Борлуулалт хариуцсан захирал, хөгжүүлэлт хариуцсан ерөнхий менежер Пьерлуижи Маринелли “Номин шиг буурь суурьтай компани, хүмүүс олох амар биш. Италичууд дөрөв биш 10 хөлтэй ширээ найдвартай гэж ярьдаг. Ийм ширээн дээр юу ч бүтээж босгож, тавьж болно гэсэн утгатай. Үүнтэй адилаар манай компани урт хугацааны бизнес харилцааг үнэлдэг. Номинтой бид ийм бизнес харилцааг өрнүүлдэг гэж бодож байна” хэмээж байв.

Тэртээ 1992 онд байгуулагдаж байсан “Номин холдинг” ХХК өдгөө борлуулалт үйлчилгээ,

импорт, экспорт дистрибушин, технологи, үйлдвэрлэл, барилга үл хөдлөх, санхүү, агаарын тээвэр гэсэн зургаан үндсэн бизнесийн чиглэлээр тус тусын зах зээлд хүчтэй өрсөлдөх чадвартай 30-аад охин компани, 6300 гаруй ажилтантай болж өргөжжээ. Сард давхардсан тоогоор хоёр сая гаруй хувь хүн, байгууллагад үйлчилдэг нь тус групп компанийн үйл ажиллагааны цар хүрээний нэг том илэрхийлэл үзүүлэлт юм. Түүнчлэн дотоодын 10 мянга орчим жижиг, дунд үйлдвэрлэгч, хувиараа бизнес эрхлэгчид болон гадаадын 700 гаруй брэнд, түншүүдтэй хамтран ажиллаж байна. Тус групп хамгийн сүүлд “Чингис Аэрлайнс Юнити” ХХК-ийг үүсгэн байгуулж, 70 хүний суудалтай ATR 72-600 агаарын хөлгийн үйлчилгээг зах зээлд санал болгож эхэллээ. Тус компани нийт есөн аймагт дотоодын нислэг үйлдэж эхэлсэн нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад бодитой хувь нэмэр оруулах нь гарцаагүй.

Өнөөдөр “Номин Холдинг” групп нь хувийн хэвшлийн томоохон төлөөлөл, үндэсний хэмжээний бахархалт компаниудын нэг болсныг монголчууд хүлээн зөвшөөрдөг. Хамгийн гол нь өрхийн бизнесийг эхнээс нь босгож, 34 жилийн турш олон салбарт өндөр чадамжтай байгууллагыг, өөрөөр хэлбэл амжилттай бизнесийг бүтээсэн нь А.Шагдарсүрэн гуайн гэр бүлийн эх орондоо оруулж буй нэг том хувь нэмэр, хувь заяаны тохиол гэж ойлгоход хэтрүүлэг болохгүй. “Бид хэзээ ч уул уурхай, согтууруулах ундаа, тамхи зэрэг онцгой албан татварын бараа бүтээгдэхүүний салбарт ороогүй. Баар цэнгээний газар байгуулж үзсэнгүй. Авлига хээл хахуулиас ангид байж, шударга өрсөлдөж, татвараа үнэнч шударгаар төлж ирсэн. Монгол Улсын Шилдэг 100 аж ахуйн нэгж шалгаруулах үйл ажиллагаа 21 жил зохион байгуулагдахад тасралтгүй шилдгээр шалгарч, амжилтаа бататгасаар ирсэн” хэмээн тэрбээр өгүүлсэн.

1990-ээд оны эхэн үе нь Засгийн газрын алдарт 20-р тогтоол гарснаар мөнгөний ханш унаж, барааны үнэ өдрөөс өдөрт нэмэгдсэнээр иргэдийн амьдрал хэцүүдэж, ядуурал ихэссэн амаргүй цаг байсан. Тухайн үед нийслэлийн Октябрийн районы орлогч даргаар ажиллаж байсан А.Шагдарсүрэн хоосон дэлгүүрүүдээр картын бараа хуваарилж, айл өрх бүрд хүргэх гэж бие сэтгэл, оюун бодлоо зориулан шантралгүй ажиллаж байлаа. Гэвч энэ их ачаалал, хүнд цаг үе эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлснөөр эрүүл мэнд, гэр бүлдээ зайлшгүй анхаарах цаг ирснийг тэрбээр ойлгов.

Түмний төлөө цаг наргүй, биеэ гаргуунд нь

“Чингис Аэрлайнс Юнити” ХХК-ийг үүсгэн байгуулж, 70 хүний суудалтай ATR 72-600 агаарын хөлгийн үйлчилгээг зах зээлд санал болгож эхэллээ

Монгол орны хөгжлийг би маш өөдрөгөөр төсөөлж, монголчуудыг дэлхийг чиглүүлэх хувьтай улс гэж боддог

▶ хаян ажиллаж байсан ч түүнд өөрт нь хурааж хуримтлуулсан зүйл байсангүй. Гэхдээ Монгол Улс зах зээлийн нийгэмд эргэлт буцалтгүй шилжсэн учир ухаалгаар сэтгэж, шаргуу хөдөлмөрлөж чадсан хэн бүхэнд сайхан амьдрах боломж бололцоо нээгдээд байлаа. Чухам энэ нь өнөөгийн “Номин холдинг” хэмээх их айлын түүхийн хуудсыг эхлүүлэх анхдагч нөхцөл болжээ.

Эхлээд өрхийн үйлдвэрлэл эрхлэхээр шийдэж А.Шагдарсүрэнгийн гэргий Р.Содном гарын уртай учир гэрээрээ хүний хэрэгцээтэй төрөл бүрийн зүйл оёх болов. Тэр үед санаан зоргоор материал олдохгүй учир Арьс ширний үйлдвэрийн хаягдлаас өөдөс түүж, загвар донж нь таарсан савхин хүрэм хийсэн нь өндөр үнэ хүрч зарагдах болжээ. Улмаар үнэг, булга, тарваганы арьсаар малгай, бэлэг дурсгалын зүйлс хийсэн нь гадаад, дотоодын үйлчлүүлэгчдийн сонирхлыг ихэд татаж эхлэв. Ингээд гэр бүлийн гишүүд тухайн үеийн хэллэгээр бол хувиараа эрхлэх аж ахуй (ХЭАА) байгуулахаар санал нэгдэж, 1992 оны долдугаар сарын 11-нд “Номин-5” ХЭАА-г байгуулсан юм.

Тэрхүү түүхэн цаг үеийн талаар А.Шагдарсүрэн гуай “Гэртээ гар, хөлийн хоёр машинаар ойр зуурын оёдол хийдэг, том хүү Ш.Уламбаяр 15-р хорооллын дэлгүүрт “Дуу бичлэг” гэсэн хаягтай, пянзнаас дуу хуулдаг, одоогийнхоор бол студи маягийн магнитофон соронзон бичлэгийн хөдөлмөр эрхэлдэг байлаа. Харин ХЭАА-н гэрчилгээ авахдаа үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, орлогын тооцоог их өндрөөр бодож, “радио электроникийн үйлдвэрлэл ба засвар, гадаад дотоод худалдаа, зуучлал эрхлэх хугацаагүй эрх” авч, гэр бүлийн таван гишүүнээ бэлгэдэн “Номин-5” гэж нэрлэсэн хэмээн дурссан.

Харин дараа жилийнх нь сүүлчээр хүү Ш.Баярсайхан нь Сингапурт М.Жексоны тоглолтыг үзээд ирэхдээ цаг, утасны аппарат, камер авчирч борлуулсан нь тэр дороо зарагджээ. Анх гар цүнхтэй Сингапур явдаг байсан бол тун удалгүй онгоцны каргоогоор, сүүлдээ 20, 40 тоннын чингэлэгээр цахилгаан бараа авчирч борлуулдаг боллоо. Дөнгөж 20 гарч явсан хүүд гадаад түншүүд нь авсан барааных нь тал үнийг л урьдчилгаа болгон авч, үлдсэнийг нь борлуулсны дараа авдаг байсан нь “Номин-5”-ийг хөл дээрээ зогсоход ихээхэн дэмжлэг болсон аж. 1996 оны баяр наадмаар нэг өдөрт 70 телевизор зарж, бөөн баяр болж байсан дурсгалтай мөч ч бий.

“Номин”-гийн хамт олны бизнесийг зөвхөн арилжаа наймаа төдий бус монголчуудын ахуйн хэрэглээний соёлд хувьсгал хийсэн чухал үйл явдал гэж үзэж болно. Үнэхээр л Япон, Сингапур зэрэг улсын электрон барааны шилдэг брэндүүдийн ачаар тухайн цаг үед монголчууд гар угаалга, гидрүүлгээс угаалгын машин, дэрсэн шүүрнээс тоос сорогч, өртөө шуудангаас гар утас, махны шууз, борцноос хөлдөөгч, радионоос өнгөт телевизортой болж томоохон шилжилт хийсэн юм. Өдгөө “Номин”-гоос бараа бүтээгдэхүүн, даатгалын үйлчилгээ, хивс худалдаж аваагүй монгол айл өрх огт байхгүй гэхэд хэтрүүлэг болохгүй.

А.Шагдарсүрэн гуай гэр бүлийн бизнесийнхээ амжилтын нууцын талаар “Нууцсаад байх юм ер байхгүй. Бүхий л үйл ажиллагаа ил тод байдаг. Бидний гол зорилго нь чанарын баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний болон ахуйн бараа бүтээгдэхүүнийг дээд зэргийн сэтгэл ханамжийн баталгаатайгаар хямд үнээр түргэн шуурхай хүргэх юм. Хэрэглэгч, түншүүд, нийлүүлэгч гэсэн гурван талт хамтын ажиллагааны чанар, өгөөжийг улам дэлгэрүүлж, сайжруулж байдаг” гэж өгүүлсэн юм.

Гэр бүлийн бизнес гэдэг компанийн засаглалын хувьд бас тийм ч амар сорилт биш. Өөрөөр хэлбэл, гэр бүлийнхээ бүх санхүү, хөрөнгө хүч, цаг хугацааг нэгэн зүйлийн төлөө зориулж, дэнчин тавьж ажиллах зоригтонгууд олон биш. “Номин холдинг”-ийн хувьд гэрийн эзний хичээл зүтгэл, цаг хугацаатай уралдан ажилладаг сахилга бат, гурван хүүгээ зөв сурган хүмүүжүүлж, мэдлэг ур чадвараар “цэнэглэж” чадсан нь тэдний амжилтын бас нэг нууц болов уу гэж бодогдоно.

Үүний үр дүнд л олон салбарын бизнес, охин компаниуд нь улсынхаа төсөвт дорвитой хувь нэмэр оруулдаг, найдвартай татвар төлөгч, нийслэл төдийгүй хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн найдвартай түнш, үндэсний шилдэг аж ахуйн нэгж болж чадсан нь гарцаагүй.

Төр түшилцсэн он жилүүд

“Монгол орны хөгжлийг би маш өөдрөгөөр төсөөлж, монголчуудыг дэлхийг чиглүүлэх хувьтай улс гэж боддог. Төрийн мэлмий гийхгүй бол түмний нүд сохорно, төрийн багана доргиход гэрийн багана хугардаг гэсэн үг бий. Тийм учраас төрийн нуруу түвшин, түмэн олон амгалан байх нь маш чухал” хэмээн өгүүлэх ▶

- ▶ А.Шагдарсүрэн гуай 1969-1976 онд МҮЭ-ийн төв зөвлөлд барилга, ой, мод боловсруулах үйлдвэрийн ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн төв хорооны анхны нарийн бичгийн дарга, МҮЭ-ийн соёлын төв ордны анхны дарга, Сүхбаатарын районы намын хорооны үйлдвэр үйлчилгээ эрхэлсэн анхны нарийн бичгийн дарга, Октябрийн районы ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны орлогч дарга зэрэг төрийн хариуцлагатай албан тушаал хашиж байв.

Гэхдээ 2000-2004 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажилласан нь түүний хувьд олон жил удирдах албан тушаал хашсан туршлага, мэдлэгээ төр нийгэмдээ зориулах хамгийн өндөр босго, тавцан байсан юм. Анх түүнийг бизнесээ орхиод, эрх баригч намын дарга, Ерөнхий сайд асан Р.Амаржаргалтай өрсөлдөх болсныг сонсоод “Шаагаа шал дэмий юм хийх юм. Бизнесээ хөөгөөд мөнгөө олоод явж байвал барав” гэсэн яриа хүртэл гарч байсан гэдэг. Өөрөөр хэлбэл, түүнийг ийм чанга өрсөлдөгчтэй таараад ялалт байгуулна гэж хэн ч төсөөлөөгүй. Харин А.Шагдарсүрэн гуайн хувьд бизнес нь түүний эцсийн бөгөөд гол зорилго хэзээ ч байсангүй, харин төр улсдаа ихийг хийх, бусдад тустай зүйл бүтээхийг л зорьсоор ирсэн байлаа.

Тэрбээр УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаандаа Эдийн засгийн болон Төсвийн байнгын хорооны гишүүн, дөрвөн орны (Япон, БНХАУ, Австрали, Канад) парламент хоорондын бүлгийн гишүүнээр ажилласан. Түүнчлэн Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бүртгэл, Тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ахалснаас гадна эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой хэд хэдэн хуулийн ажлын хэсэгт орж үр дүнтэй ажиллажээ. Нэгэн сонирхолтой тоо дурдахад, 2000-2004 оны хооронд УИХ нийт 990 хууль, тогтоол батлан гаргасны 26 хувийг Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороогоор хэлэлцсэн нь тус хорооны ажлын цар хүрээг харуулдаг.

Төрийн эрх барих дээд байгууллагад олон хууль тогтоомжтой “зууралдаж” ажилласан дөрвөн жилийн хугацаанаас нь зөвхөн нэг хуулийг онцольё. Тэрбээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг боловсруулсан ажлын хэсгийн ахлагчийн хувьд 2002 онд “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлагадаа “Уг хууль нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг



хамгаалж, тэднээс хуульд захирагдах үндсэн дээр аж ахуйгаа чөлөөтэй эрхлэх боломжит нөхцөлийг бүрдүүлэх, төрөөс аж ахуй эрхлэхэд оролцох хүрээг аль болох багасгаж, хүнд суртал, авилгалын механизм үйлчлэх орчныг хааж, хөнгөн шуурхай, чирэгдэлгүй төрийн үйлчилгээ бий болгоход бүхэлдээ чиглэсэн ихээхэн ач холбогдол бүхий төрийн бодлогын цогц гэж хэлж болно” хэмээн онцлон дурдсан байдаг.

Эдгээрээс гадна газар өмчлөл, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, Мянганы зам, банкны салбар зэрэг улс орны хөгжлийн нэн чухал чиглэлийн хууль, тогтоолуудыг боловсруулах, батлах, эрх зүйн орчныг



▶ “Номин”-гоос бараа бүтээгдэхүүн худалдаж аваагүй монгол айл өрх огт байхгүй гэхэд хэтрүүлэг болохгүй

бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг нь дурдууштай. УИХ-ын гишүүнээр ажилласан талаараа “Төрөө түшилцсэн мину” дурсамж ном бичсэн нь төр барилцах хугацаандаа хийсэн ажилтай, бүтээсэн зүйлтэй ажилласан гэдгийг нь нотлох бүтээл болжээ.

А.Шагдарсүрэн гуай тэрхүү дөрвөн жилийн талаар “Эх орны өнцөг булан бүрээс шилэгдэн ирсэн олон сайхан нөхөдтэй парламентын танхимд дөрвөн жил амь амьсгаа нэгтэй ажиллана гэдэг үнэхээр их завшаан, бас төр түшилцэх том сургууль байлаа. Лавшруулан судалж, маргаж мэтгэлцэх хэрээр асуудлынхаа гүнд орж, ухаарч таньж, улмаар бие биеэсээ

суралцаж явсан энэ үе маань миний амьдралын нэгэн сайхан үе байсан. Олон сайхан өсөх ирээдүйтэй, шилдэг түшээдтэй хамтран ажилласан маань их хувь тохиол юм даа” хэмээн дүгнэн өгүүлсэн байдаг.

Алс баруун хязгаарын торгууд хөвгүүн эрдэм мэдлэг, хөдөлмөрийг эрхэмлэж, тууштай сахилга бат, цагийг эрхэмлэгч нандин чанартаа тулгуурлан төр түшилцэж, улсынхаа хамгийн том групп компаниудын нэгийг үүсгэн байгуулсныг одоо эргэн харахад мөн их хувь тохиол юм даа гэсэн бодол энэхүү нийтлэлийг тэрлэн байхад өөрийн эрхгүй төрж байлаа. ■

МОНГОЛ ХҮН АМЖИЛТАД ХҮРЭХ НУУЦААС

Хүн бүр сурч, хөдөлмөрлөе

Хүн өөрийгөө таних их чухал. Би юу хийж чадах вэ, миний хобби юу вэ гэдгээ ойлго. Тодорхой мөрөөдөл, зорилготой байж түүнийхээ төлөө жинхэнээсээ тэмүүлэх ёстой. Тэмүүлнэ гэдэг нь чадна, хийнэ гэсэн бат итгэлтэй болохыг хэлж байгаа юм.

Бэрхшээлийг давах тэсвэр, тэвчээртэй бай

Мөрөөдөлдөө хүрэхийн тулд хатуужил, тэвчээртэй байж, ямар ч бэрхшээл саадыг даван туулаарай. Бүтэхгүй байвал аргаа өөрчлөөд дахин оролд. Бусдын хийснийг ажигла. Саадыг аль болох давах талаас нь бод, сэтгэ, оролд, юун дээр алдав гэдэгтээ дүгнэлт хийж байж л амжилтад хүрнэ. Амжилт гаргахын хэрээр урамшаад, ядарч цуцахаа мэдэхээ байж урагш тэмүүлдэг юм. Гэхдээ олон юмны хойноос хөөцөлдвөл оргүй болдог талтай. Тиймээс нэг зүйлд илүү шунан

тэмүүлж ажиллах хэрэгтэй. Хүн ганцаараа юм бүтээхэд хэцүү. Заавал хамтрагч, түнш хэрэгтэй. Харин сонголтоо зөв хий.

Төлөвлөгөөтэй ажилла

Ямар нэгэн юм хийх гэж байгаа бол заавал төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Ажлаа өдөр, сар, жилээр төлөвлөж, түүндээ хүрэх ёстой.

Бусдын үгийг нухацтай сонс

Бусдын туршлага, үгийг сонсож сур, ухаарал ав. Монголчууд шүүмжлэлд их эмзэг. Гэхдээ эмзэглэх бус яагаад шүүмжлэв гэдгийг өөрөөсөө асууж, өөртөө дүгнэлт хийж байх ёстой. Дутагдлаа бага багаар засаж явсаар амжилтад хүрнэ. Амжилтад хүрээд сэтгэл ханаж болохгүй, бардам зан гаргаж болохгүй. Даруу бай. Бизнес эрхэлж, байгууллага удирдаж байгаа хүн өөрийн биеэр үлгэрлэж, бусдыгаа дагуулж байх ёстой.

ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨГӨӨ

- Хамт олныг нэг цул болгодог, хөгжүүлдэг зүйл бол тэднийг урамшуулах явдал юм. Яаж урамшуулах вэ гэвэл цалингаар. Цалин нь тухайн хүнийхээ ур чадварт, хийж байгаа зүйлд нь тохирсон байх ёстой.
- Хамт олон зөв бүрдэж, нэг чигт хандсан байх юм бол амжилтад гарцаагүй хүрнэ. Улс орон ч ялгаа байхгүй, ингэж байж л хөгжинө.
- Бизнес буюу мөнгө арвижуулах ухаан гэдэг бол таваарыг мөнгө, мөнгийг таваар болгон хувиргаж, энэ эргэлтийн үе шат бүрээс ашиг олох үйл явц юм.
- Ашиг хонжоо олох боломжийг алдахгүй байх, үнэ ханшийн хэлбэлзлийг самбаачлан ашиглах, эрэлтийг мэдрэх явдал бол бизнесмэн хүний ажиллах үндсэн зарчим байдаг.
- Дараа их ашиг олохоос одоо багахан ашиг олох нь дээр.
- Мөнгөтэй хүн бүр “дэмий үрэхгүй”, “зээлдүүлэхгүй”, “шахалтан дор мөнгө гаргахгүй” гэсэн зарчмуудыг хатуу баримтлах ёстой.
- Мөнгийг мөнхийн эргэлт, хөдөлгөөнд байлгаж ашиг олдог. Ашгийн хэмжээ нь мөнгөн дүнгийн их, багаас илүүгээр худалдааны хурдаас шалтгаална.
- Эргэн тойрон орчноосоо юм тусган авч, хөгжлийн хэтийн төлөв хандлагыг мэдрэх нь чухал.
- Ухаалаг хэрэглээ бол мөнгийг арвижуулах бас нэг арга мөн.



ШИНЭ ЖАРНЫ БОСГОН ДЭЭРХ “ТАНХИМ”

МҮХАҮТ-ын институцийн хөгжил, экосистемийн хувьслыг “Танхимын хууль” тодорхойлно.

Монголын төрийн бус байгууллагуудын хөгжлийн нэгэн тод жишээ бол МҮХАҮТ. Түүхийн хуудсынхаа бараг тэн хагасыг социалист нийгэмд “бичсэн” энэ байгууллага төрийн яамны харьяанд байгуулагдаж байсан ч 1990 онд цаг үеийн салхийг хамгийн түрүүнд үүдээрээ нэвтрүүлсэн юм. Тухайн үед хувийн хэвшлийн дуу хоолой институцжих шаардлагатай байснаас гадна чиг үүргээ

Шинэ жарандаа хөл тавиад буй МҮХАҮТ ирээдүйгээ бүр ч өөдрөгөөр төсөөлж байна

бодсон ч чөлөөт зах зээлийн “сүнс”-ийг танхим л сэрээх учиртай байлаа. Ингээд танхим Монголын хамгийн анхны төрийн бус байгууллага болсон юм.

Өдгөө МҮХАҮТ аймаг бүрд салбар танхимаа байгуулж, 6700 гаруй гишүүнтэй болжээ. Үүгээр зогсохгүй гадаад ертөнцөд ч хамтрал, түншлэлээ тэлсээр байна. Олон мянгаар тоологдох “төрийн бус”-ууд дунд танхим шиг ийн хэлбэрээ олсон нь тун цөөн. Нөгөөтээгүүр, танхим бол хувийн хэвшлийнхний тод дуу хоолой, бодлогын хэлэлцүүлгийн гол оролцогч. Монголын бизнесийн экосистемийн “цаг уур”-ыг тодорхойлогч. ▶



Тиймдээ ч “институцын хөгжлийн тод жишээ” гэж нийтлэлийн эхэнд онцолсон нь учиртай.

Шинэ жарандаа хөл тавиад буй МҮХАҮТ ирээдүйгээ бүр ч өөдрөгөөр төсөөлж байна. Гэхдээ эл төсөөллөө бодит болгохын тулд 30 жилийн өмнөх “танхимын хууль”-аа шинэчилж, олон улсын танхимын чиг хандлага, бизнесийнхний хөгжлийн хурдтай алхаагаа тааруулах шаардлагатай. Хэрэв УИХ 31 жилийн өмнөх Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулиа эргэн харахгүй бол бизнесийнхний “тушаа” тавигдахгүй.

Хүлээлт дагуулсан хууль

Зах зээлийн эдийн засгийн нөлөөгөөр үүрэг нь огцом тэлсэн МҮХАҮТ 1995 онд өөрийн гэсэн хуультай болсон. Энэ үйл явдал танхимыг институцийн бие даасан байдалтай болоход маш хүчтэй нөлөөлсөн. Гэсэн ч нэгэн цагт үнэ цэнтэй байсан хууль өдөр хоногоор өсөж буй бизнесийн талбарт “гологдож” эхэлсэн юм. Дэлхийн эдийн засгийн давлагаа өөрчлөгдөж, дотоодын бизнесийн орчинд салхи эргэх хурд нэмэгдсэн. Үүнээс гадна хувийн хэвшлийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээ шаардлага сүүлийн 30 жилд ихээхэн өөрчлөгдсөн. Иймээс “танхимын хууль”-ийг шинэчлэх зайлшгүй шаардлага бий.

Цаг үеийн шаардлагын дагуу танхимаар овоглосон үе үеийн удирдлагууд болон бизнесийнхний төлөөлөл шинэ хуулийн төсөл боловсруулж, улмаар УИХ-ын гишүүн Х.Ганхуяг, Д.Энхтүвшин нар 2025 оны арванхоёрдугаар сарын 17-ны өдөр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлээд буй. Одоо танхимынхан энэ хуулиа хоног тоолон хүлээж байна.

Хуулийн төслийг 200 гаруй жилийн түүхтэй Францын арилжааны код, 130 улсын 45 сая компанийг эгнээндээ нэгтгэсэн 100 гаруй жилийн түүхтэй дэлхийн хамгийн том бизнесийн байгууллага Олон улсын худалдааны танхимын сүлжээний бодлого зохицуулалтаас үлгэр авч, дотоодын бизнесийн орчинтой уялдуулан гол концепцыг нь боловсруулжээ. Ингэснээр далайд гарцгүй, жижиг зах зээлд өрсөлдөж буй томоохон аж ахуй нэгжүүдэд гадагш тэлэх боломжийг бүрдүүлж чадна гэж танхимын удирдлага үзэж байна.

МҮХАҮТ бол Олон улсын худалдааны танхим,

Дэлхийн танхимуудын холбооны гишүүн байгууллага. Иймдээ ч олон улсын бизнесийн харилцааны жишиг зохицуулалтыг зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай. Мөн олон улсын танхимуудын адил зарим төрлийн нийтлэг үйлчилгээ, бүрэн эрхийг хэрэгжүүлдэг болсноор өнөөгийн бизнесийн орчинд ахиц авчирна гэсэн хүлээлттэй байгаа аж.

Нөгөөтээгүүр, танхим хувийн хэвшлийн албан ёсны төлөөлөл болох зорилгоо шинэ хуулиар дамжуулан хэрэгжүүлэх хүсэлтэй байна. Монгол Улсын Үндсэн хуульд олон хэвшилт эдийн засгийг хөгжүүлэх чиг баримжаа туссан боловч хувийн хэвшлийг хэн төлөөлөх нь тодорхой бус, орхигдсон байдаг. Хэдийгээр 30 мянган төрийн бус байгууллага янз бүрийн

Дэлхийн танхимуудын адил гишүүнчлэлийн хосолмол загварт шилжих саналаа хуулийн төсөлд тусгаад байна

эрх ашгийг төлөөлж байгаа ч тэдний зарим нь улс төрийн нөлөөллийн хэрэгсэл болж хувирсан нь нууц биш гэж МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа хэлж байсан юм.

Хэрэв танхимыг хуулийн хүрээнд хувийн хэвшлийн албан ёсны төлөөллийн төв байгууллага болгон

тодорхойлбол бодлогын хэлэлцүүлгийн чанар сайжирч, хувийн хэвшлийн дуу хоолойг институцжүүлэх суурь болно. Ийм ч учраас шинэ хуульд МҮХАҮТ-ын нэгэнтээ хүлээн зөвшөөрөгдсөн төлөөллийн мандатыг албажуулах талаар тусгасан байна.

Хуулийн төсөлд үүгээр тогтохгүй өөр олон шинэ зохицуулалт багтжээ. Тухайлбал, дэлхийн танхимуудын адилаар сайн дурын болон албан журмын гэсэн гишүүнчлэлийн хосолмол загвартай болох талаар тусгасан нь анхаарал татаж байв. Ингэхдээ НӨАТ төлөгч аж ахуйн нэгжүүдийг эхний ээлжинд албан журмын гишүүнчлэлд хамруулах бол ЖДҮ эрхлэгч иргэнийг сайн дурын үндсэн дээр оролцуулах талаар тусгажээ. Үүний үр дүнд танхимын төлөөллийн хүрээг тэлэх, том бизнесийг системд татах, жижиг бизнесийг шахахгүй үлдээх тэнцвэрийг олно гэж төсөл боловсруулагчид тайлбарлаж байна.

Мөн аливаа бизнесийг орон нутаг, бус, олон улсын түвшинд шаталсан байдлаар дэмжиж, гадаад зах зээлд гарах боломжийг нь ▶



Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын дарга Н.Учралд өргөн мэдүүлж буй нь. 2025.12.17

“Танхимын түүх бол ерөөс нэг байгууллагын түүх биш. Институцийн хөгжил, экосистемийн хувьслын түүх байх болно”

- ▶ нэмэгдүүлэх үүднээс тухайн дэмжлэгээ ЖДҮ-ийг бойжуулах бодлоготой уялдуулах талаар ч төсөлд дурджээ.

Монголын хувийн хэвшил тодорхой түвшинд хүрч, дараагийн шатны хөгжил рүү тэмүүлж буй энэ үед шинэ хууль нь зөвхөн байгууллагын тухай биш, харин Монголын эдийн засгийн “төлөөллийн архитектур”-ыг шинэчлэх түүхэн оролдлого гэж тодорхойлж болох юм. Гагцхүү хаврын чуулганы үр дүнгээс хүлээлт дагуулсан энэ хууль цаашид хэрэгжих эсэх нь хамаарна.

Дэлхий дахинд худалдаа, аж үйлдвэрийн танхимууд эдийн засгийн бодлогын “зөөлөн дэд бүтэц” болж хөгжсөн байдаг. Германы ІНК систем, Францын танхимын сүлжээ, БНСУ-ын КССІ зэрэг жишээг үзэхэд, танхимууд зөвхөн бизнесийг төлөөлөхөөс гадна мэргэжлийн боловсрол, стандартчилал, экспортын дэмжлэг, бүр зарим тохиолдолд төрийн чиг үүргийг гүйцэтгэх түвшинд хүрсэн байна.

Эдгээр орны туршлагаас танхим нь институцийн хувьд тодорхой эрх үүрэгтэй, төлөөллийн хүрээ нь өргөн, бодлого боловсруулах үйл явцад албан ёсоор оролцдог нийтлэг хэв шинжтэй болохыг ажиглаж болно. Харин Монголын хувьд танхим “сайн дурын нэгдэл” шинжтэй байгаа нь хөдлөх орон зай, бодлогын нөлөөллийг нь хязгаарлаж ирсэн гэвэл хилсдэхгүй.

Танхимын шинэ жаран

Хууль батлагдвал танхимын ирэх жарны өнгө

өөрчлөгдөх учиртай. Өнгөрсөн хугацаанд танхим бизнесийнхний дуу хоолой байсан бол цаашид эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд оролцогч гол институц болно.

Өдгөө Монголын эдийн засаг уул уурхайн салбарт хэт төвлөрсөн хэвээр байгаа. Энэ бүтэц гадаад шоконд эмзэг байдлыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хязгаарладаг. Ийм нөхцөлд танхимын эрх үүрэг, цар хэмжээ тэлбэл экспортын төрөлжилтийг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг гадаад зах зээлтэй холбох, бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гол хөтөч нь болно. Дэлхийн танхимууд ч ийм л жишгээр ажилладаг.

МҮХАҮТ шинэ жарныхаа өнгийг тодорхойлохын тулд, багагүй судалгаа хийсэн. Энэ хүрээнд гадаад хамтын ажиллагааг тэлж, төрийн айлчлалуудад голлох байр суурьтай оролцож байна. Ингэснээр туршлага судлаад зогсохгүй бизнес хооронд хил дамнасан холбоос үүсгэж, хамгийн чухал нь шинэ зах зээлийн үүдийг нээж байна. Мөн дипломат харилцааг эдийн засгийн бодит үр дүнд хүргэх чухал механизм нь танхимын гадаад харилцаа болоод байна.

Өнгөрсөн хугацааны бодлого, үйл ажиллагааны үр дүнд Евро-Азийн бүсэд шинэ боломж нээгдэж, ирэх жаранд 200 гаруй сая хэрэглэгчтэй зах зээл бидэнд найрсагаар үүдээ нээнэ гэсэн хүлээлт ч танхимынханд байна. Мөн өмнө нь гаалийн өндөр татварын улмаас гадаад худалдааны боломж хязгаарлагддаг байсан бол шинэ нөхцөлд экспортын чадавхыг бодитой нэмэгдүүлэх гарц “танхимын цонх”-оор илхэн харагдаж байгаа бололтой.

Гагцхүү танхим хуулиар дамжуулан хөдлөх орон зайгаа л тэлэх хүсэлтэй байна. Хэрэв шинэ хууль, шинэ бодлого, шинэ манлайлал хоорондоо уялдаж чадвал танхим эдийн засгийн “зөөлөн дэд бүтэц”-ээр барахгүй хөгжлийн хурдасгуур болж чадна гэдэгтэй итгэлтэй байна. Мөн тэд “Танхимын түүх бол ерөөс нэг байгууллагын түүх биш. Институцийн хөгжил, экосистемийн хувьслын түүх байх болно” хэмээн онцлон тэмдэглэж байна. ■



WELCOME TO
THE BIGGEST
Souvenir
Center



Бизнесийн орчинд гэрэл асаах найдвар тээсэн 10 гаруй хуулийн төслийг энэ хавар УИХ-ын чуулганы танхимд хэлэлцэнэ. Ялангуяа Нийгмийн даатгал болон Татварын багц хуулийн шинэчлэл, Хөрөнгө оруулалтын хуулийн “засвар”, Арилжааны хууль, Танхимын хууль, Зээлийн хүүд хязгаар тогтоох тухай хууль хамгийн их хүлээлт дагуулж байна. Гагцхүү УИХ ажлаа хийж чадах эсэхээс хамааран энэ хүлээлт дуусгавар болно, эсхүл дахин үргэлжилнэ. Хэрэв хүлээлт хүссэнээр шийдэгдвэл энэ хавар эдийн засаг, бизнесийн орчинд “реформын хавар” ирэх учиртай.

Б.Лхагважав

МҮХАУТ-ын Ерөнхийлөгч,
Монгол Улсын гавьяат
эдийн засагч

УИХ ажлаа хийж чадвал энэ хавар
“РЕФОРМЫН ХАВАР” болно



► **Татварын багц хууль дөрвөн удаа шинэчлэгдсэн ч бизнес эрхлэгчдийн “зовлон” татвар хэвээр байна. Тиймээс та хуулийн шинэчилсэн төсөлд ямар өөрчлөлт тусгасан талаар ярилцлагын эхэнд мэдээлэл хүргэхгүй юу?**

Өнөөдөр та бид 30 гаруй төрлийн татвар, шимтгэл, хураамж төлж байна. Олон янзын нэртэй боловч үндсэндээ төсвийг бүрдүүлэгч гол цөм нь бидний төлж байгаа татвар юм. Татварын систем боловсронгуй болж байгаа. Өнгөрсөн хугацаанд хийсэн өөрчлөлт, шинэчлэл бүр татварын ачааллыг бууруулахад чиглэж ирсэн. Тухайлбал, ААНОАТ 10 хувь, 25 хувь гэсэн хоёр шатлалтай байсан. Зургаан тэрбум төгрөгөөр босго тогтоож ингэж шатлалд хуваадаг. Харин 2019 оны зохицуулалтаар 1.5 тэрбум төгрөг хүртэлх орлоготой аж ахуйн нэгж тайлангаа өгөөд төлсөн татварынхаа 90 хувийг буцааж авах боломж бүрдсэн. Өөрөөр хэлбэл, татварын бодит ачаалал 10 хувь болж буурсан. Одоо Монголын компаниудын 90 хувь нь энэ ангилалд багтаж байна.

Харьцуулбал, иргэд НӨАТ-ынхаа 20 хувийг буцааж авдаг бол аж ахуйн нэгж 90 хувийг буцаан авч байна. Тэгэхээр ААНОАТ дарамт биш. Асуудал нь шатлалын босго, татварын процесст бий. Тиймээс зургаан тэрбумын босгыг 12 тэрбум болгох шаардлагатай. Мөн 25 хувийн шатлалд хүрэхээс өмнө 15 хувийн буюу дундын шатлал нэмэх хэрэгтэй байгаа. Энэ талаар төсөлд тусгасан. Харин татварын процессын тухайд, жишээ нь НӨАТ-ын тайланг сар бүр гаргадаг. Үүнийг сар бүр биш улиралд нэг удаа гаргадаг байхад л хангалтай. Сар бүр тайлан гарга гэдэг чинь л дарамт.

НӨАТ-ын талаар маш олон шүүмж байдаг. Та НӨАТ-ын тогтолцоог шүүмжилж, шинэчлэл сайжруулалт хийхэд гар бие оролцож явсан хүний хувьд, тэдгээр шүүмжид ямар тайлбар өгөх вэ?

Дэлхийн 100-аад улс “value-added tax” буюу НӨАТ-ын систем хэрэглэж байна. Манай улс анх 1997 онд хуулиа баталж, 1998 оноос НӨАТ-ын тогтолцоог бий болгосон. Үндсэндээ өмнө нь байсан “худалдааны татвар”-ыг шинэчилж, НӨАТ-ыг гаргаж ирсэн. Гэхдээ 1998-2016 оны хооронд мөрдөгдөж байсан Татварын хууль учир дутагдалтай байсан. Үүнээс шалтгаалж НӨАТ философиосоо

гажсан юм. Компаниудыг маш их жижиглэсэн. 10 сая төгрөгийн босго тавиад уг босгыг давсан аж ахуйн нэгж НӨАТ төлөгч болно гэж хуульчилсан болохоор компаниуд зориуд орлогоо багасгаж, тайлангаа нуудаг болсон. Бүр олон жижиг компани болж хуваагдах нөхцөл рүү түлхсэн. Зарим хүн 100 компани байгуулж байсан тохиолдол ч бий. Ер нь Татварын хуульд тоогоор босго тавихдаа маш сайн бодох ёстой.

Тэр үед, 2005 онд би иргэний хувиар Үндсэн хуулийн цэцэд хүртэл хандсан. Гэхдээ миний талд шийдвэр гараагүй. Дараа нь учрыг асуухад, хэрвээ шийдвэр миний талд гарсан бол 1998-2005 оны бүх акт хүчингүй болж, төр асар их мөнгө буцааж өгөх эрсдэлтэй тулгарах байсан гэж хэлж байсан. Харин одоо босго 50 сая төгрөг болсон. Өнөөдөр НӨАТ-ын баримт өгдөггүй газар байвал жижиг, бүртгэлгүй бизнес хийж байгаагаа л харуулж байна гэсэн үг.

Сүүлийн 10 жилд НӨАТ-ын систем маш их сайжирсан. Иргэд 20 хувийн буцаан олголт авч байна. Улсын төсөв бүрдэхэд нөлөө үзүүлж байна. Гуравдугаарт, бэлэн бус гүйлгээгээр дамжуулан банкны систем НӨАТ-ын шинэчлэлээс хамгийн их хожсон. 2016 оны нэгдүгээр сарын 1-нд шинэ хууль хэрэгжиж эхлэхэд 1600 кассын машин, 14 мянган ПОС төхөөрөмж байсан. Нэг жилийн дараа 100 мянга, хоёр жилийн дараа гэхэд 200 мянга болсон. Харин өнөөдөр 350 мянган цэг дээр НӨАТ-ын баримт бичиж байна. Үүний 250 мянга нь ПОС төхөөрөмж. Тэгэхээр банкуудад ямар нөлөөтэй гэдэг нь ойлгогдож байгаа биз.

Хуулийн төсөлд НӨАТ-ын талаар ямар зохицуулалт тусгасан талаар та бүр илүү тодруулж хариулт өгөхгүй юу?

Иргэдийн авдаг буцаан олголтын хэмжээг нэмэгдүүлж, 20 биш, зарим тохиолдолд бүр 100 хувьд хүргэнэ. Та бүхэн санаж байгаа бол өнгөрсөн жилийн төсөв батлах үед нэг өөрчлөлт орсон. Аравдугаар сарын 1-нээс эхлээд буцаан олголтыг шаталсан байдлаар хэрэгжүүлэхээр тусгасан. Буцаан олголтыг ингэж шатлалтай болгосноор систем бүхэлдээ сайжирч, татвар төлдөггүй байсан бизнесүүдээс ч татвар авах боломж бүрдэнэ. Бас нэг чухал зүйл бий. Нягтлан бодох бүртгэлд аккрузул суурь, мөнгөн суурь, холимог суурь гэсэн гурван хэлбэр байдаг

Манай эрх баригчдад нэг сонин хандлага байна. Хуульдаа гоё юм биччихнэ. Гэхдээ тэрийгээ иргэндээ эдлүүлэхгүй гэсэн шиг хэцүү нөхцөл тулгадаг

Уран барималч
Д.Түвдэндоржийн
2025 оны бүтээл
"Нөат-мэн". Энэхүү
бүтээл дээрх QR
кодыг уншуулан
НӨАТ-ын ач
холбогдол, онцлог
тоон үзүүлэлттэй
танилцах
боломжтой.



Бидний
хувьд
нэг л зүйл
чухал.
Бизнесийн
орчинд хийх
системийн
өөрчлөл-
түүдийг л
баталж
өгөөсэй.
Дараа нь
УИХ
тарна уу,
үгүй юу,
тэр
хамаагүй

► юм. Одоогийн татварын систем ихэвчлэн аккруэл суурьтай явж байгаа. Энэ нь орлого, зардлыг мөнгө орж ирсэн эсэхээс үл хамааран бүртгэдэг арга. Харин НӨАТ мөнгөн суурьтай явах ёстой. Мөнгө орж ирсэн үед л орлого орлоо гэж гэж үзье, тэгээд татвар ярья. Бодит байдал дээр борлуулалтын орлого хэдэн сарын дараа орж ирэх үе бишгүй байдаг. Гэтэл энэ хооронд орж ирээгүй орлогынхоо төлөө татвар төлөх болдог. Үүгээр зогсохгүй хугацаандаа төлөөгүй бол алданги тооцдог. Ингэж НӨАТ-ын өр хуримтлагддаг. Тэгэхээр НӨАТ-ыг мөнгөн суурьт шилжүүлж байж л асуудал шийдэгдэнэ. Ийм л шинэчлэл НӨАТ дээр ярьж байна. Мөн гааль дээрх НӨАТ-т өөрчлөлт оруулах талаар тусгасан. Тодорхой шалгуур хангах компаниудаас гааль дээр НӨАТ авахгүй, зөвхөн гаалийн татвар л авна. НӨАТ-ыг хойшлуулж төлөх боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр НӨАТ-ыг дээр дурдсан “мөнгөн суурьтай татвар” гэдэг сонгодог утга руу нь ойртуулж байгаа хэрэг.

Таны өрөөнд байгаа QR кодтой баримал их сонирхолтой юм. Ямар учиртай бүтээл вэ?
Энэ их сонин түүхтэй. Би өнгөрсөн намар Шотланд руу хувийн шугамаар найз нөхөдтэйгөө явсан юм. Тэгэхэд Шотландын

Эдинбург хотод нэг хөшөөтэй таарсан. 25 насандаа Их Британийн ерөнхий сайд болж байсан Пит Виллиам гээд Шотланд хүний хөшөө Пит Виллиамын түүхэн гавьяа хийгээд ерөнхий сайд болсон шалтгаан нь ХХОАТ-ын системийг бий болгосонд оршдог. Одоо та бидний цалингаасаа төлдөг татвар шүү дээ. Түүнийг энэ татварыг санаачлахаас өмнө татварыг голдуу баян хүмүүс л төлдөг байсан. Чинээлэг хүмүүс татвар төлснөөрөө буцаагаад хаанаасаа маш их эрх мэдэл, бизнесийн давуу тал олж авдаг байсан. Харин Пит Виллиам иргэн бүр татварт хамрагддаг механизм бий болгосон. Өдгөө ХХОАТ дэлхийн 200 гаруй улсад хэрэглэгдэж байна. 200 гаруй жилийг ардаа үлдээгээд байна. Түүний нээлтийн үр дүнд Их Британийн хааны сан хөмрөг асар их тэлсэн. Мэдээж хүн болгон татвар төлөөд эхлэхээр өмнө нь байгаагүй өөр механизм ажиллаж эхэлсэн. Тэгэхээр энэ хүнийг татварын системд маш том нээлт хийсэн хүн гэж тодорхойлж болно.

Ингээд л бүтээлийн санаа төрж, Польшид төгссөн уран барималч Д.Түвдэндоржтой үзэсгэлэн дээр таарч ярилцсан. Д.Түвдэндорж монголчуудын баг хийдэг цаасан шуумлын аргаар энэ бүтээлийг хийсэн юм. Манайхны сайн мэдэх цамын бүжигт ашигладаг багийг энэ аргаар хийдэг. Бүтээлийг хийхдээ миний нүүрний хэвээр хийсэн. Ингэж л “Нөат-мэн” хэмээх энэ дүр бүтсэн. Намар болсон нэг үзэсгэлэн дээр энэ бүтээл маань тавигдсан. Манайд НӨАТ-ын шинэ хууль хэрэгжээд 10 жил болж байна. Сүүлийн 10 жилд манай татварын орлого жил бүр доод тал нь 10 хувиар давж биелж ирсэн. Энэ нь НӨАТ-ын бүртгэл сайжирсантай холбоотой. Түүнээс гадна бусад татварын орлого ч нэмэгдсэн. НӨАТ-ын онцлог юу гэхээр, иргэддээ төлсөн татварын 20 хувийг буцааж өгдөг, дээрээс нь сугалаа явуулдаг. Ийм хосолсон систем дэлхий дээр бараг байхгүй. Бразилд жаахан төстэй зүйл бий, гэхдээ манайх шиг ийм амжилттай хэрэгжсэн улс маш цөөн.

НӨАТ заавал 10 хувь байх хэрэгтэй гэж үү? Ер нь бусад улсад ямар байдаг вэ?

Манай НӨАТ 10 хувь. Бусад оронд 7-25 хувь байдаг. Энэ утгаараа манайх дундаж. Харин бидний давуу тал нь иргэддээ буцааж өгдөг. Жилд ойролцоогоор нэг их наяд төгрөгийг ►

► иргэд буцааж авч байна. Авахад ч бараг саад байхгүй, амархан. Гэхдээ бусад татвар дээр бол эсрэгээрээ. Хэцүү зүйлс их байна. Жишээ нь, ХХОАТ байна. АНУ-д иргэд тайлангаа өгөөд 70-80 хүртэлх хувиа буцааж авч чаддаг. Гэр бүл, хүүхэд, боловсрол гээд бүгдийг тооцдог. Манайд ч бас хөнгөлөлт бий. Нийтдээ 20 орчим хөнгөлөлт, чөлөөлөлт байдаг. Гэхдээ буцааж авах гэхээр материал бүрдүүлэх нь төвөгтэй, ихэнх хүн замаасаа шантардаг. Дээрээс нь хугацааг нь хар. Хорлонтой юм шиг хоёрдугаар сарын 15-наас өмнө өг гээд хугацаа тулгачихдаг. Гэтэл яг тэр үед нь компаниудын тайлан гарч байдаг. Хүн өөрийнхөө бодит орлогоо ч бүрэн мэдээгүй байхад хугацаа нь дуусчихдаг. Ингээд л буцаалт авах боломж нь байсаар байхад авч чаддаггүй. Одоо шинэ хуулиар зургаадугаар сарын 1 хүртэл сунгана гэж яригдаж байна. Энэ бол арай боломжийн хугацаа. Ер нь манай эрх баригчдад нэг сонин хандлага байна. Хуульдаа гоё юм биччихнэ. Гэхдээ тэрийгээ иргэндээ эдлүүлэхгүй гэсэн шиг хэцүү нөхцөл тулгадаг.

Татвараас гадна нийгмийн даатгалын шимтгэл ажил олгогчдын толгойны өвчин болдог. Ажлын байр бий болгосон нь гавьяа биш, бараг гай юм уу гэмээр. Энэ тал дээр УИХ-д оруулсан санал санаачилга юу байна?

Тийм, энэ их чухал асуудал. Монголд ажлын байр гаргаж, хүн цалинжуулсныхаа төлөө үсээ цайлгадаг тогтолцоо байгаа нь үнэн. Ажилчдадаа сэтгэл гаргая, цалингаа нэмье ээ гэхээр шимтгэлийн ачаалал дагаад өсдөг. Цалин өсгөх, нэмэлт урамшуулал олгох сонирхлыг бууруулдаг гол хүчин зүйл нь энэ. Тийм учраас Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлт маш их хүлээлт дагуулж байна. Одоо бид хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих цаг болсон. Цаашлаад Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийг батлах ёстой. Гэтэл нийгмийн даатгалын шимтгэл нь зээлийн шаардлага болоод хувирчихсан байна. Гэсэн хэрнээ шимтгэл төлөгчийг хамгаалах, эрсдэлийг нь хариуцах үндсэн үүргээ гүйцэтгэж чадахааргүй болж байгаа. 2030 он гэхэд Нийгмийн даатгалын сангийн алдагдал хоёр их наяд төгрөг буюу ДНБ-ий гурван хувьд хүрэхээр байгаа.

Нийгмийн даатгалын хувьд, өмнө нь би нэг санал оруулаад, хасуулж л явсан. Одоо тэр саналаа дахиад зүтгүүлнэ. Энэ нь листний мөнгийг зогсоох асуудал. Ажилтан эмнэлэгт хэвтвэл эхний тав хоногийн мөнгийг компани төлдөг. Компани ажилтныхаа ЭМД-ын 50 хувийг сар бүр төлж байж, дээрээс нь дахиад тав хоногийн мөнгө төлнө гэдэг давхардал, утгагүй асуудал. Компаниуд жилд дунджаар 24 тэрбум төгрөгийг листэнд төлж байна, үүнийг болиулах ёстой. Лист боддог зохицуулалт бол социализмын үлдэгдэл. Хоёрдугаарт, ЭМД-ыг заавал компани төлөх шаардлагагүй. Энэ чинь хувь хүний асуудал. Иргэн хүн өөрөө даатгалаа төлдөг байх ёстой.

Барууны орнуудад тэгж явдаг. Гэтэл төр хувийн хэвшлээ буяны байгууллага шиг, эсвэл зардалгүйгээр орлого олдог юм шиг хардаг. Бүх ачааллыг үүрүүлдэг. Энэ хэрээр хувийн хэвшил нухлагдаж, төрийн бүтэц данхайж байна. Байгалийн баялаг, том төслүүдээр дамжаад төр өөрөө гол тоглогч болж байгаа нь зах зээлийн эрүүл бус үзэгдэл.

Энэ удаагийн чуулганаар бизнесийн орчинтой холбоотой олон хууль хэлэлцүүлнэ. Хэрэв УИХ ажлаа хийж чадвал энэ хавар “реформын хавар” болно. Хувийн хэвшлийн ачааг хөнгөлөх, ТӨК-уудыг хувьчлах, зах зээл дэх улс төрчдийн оролцоог хязгаарлах маш чухал төслүүд бий.

Өнгөрсөн оны гурав, дөрөвдүгээр сард татвар, нийгмийн даатгалын багц хуулиар маш том хэлэлцүүлгүүд болсон. Хоёр сарын хугацаанд ойролцоогоор 250 мянган хүн оролцож, 100 гаруй мянган санал ирсэн гэсэн тоо ч бий. Гэхдээ тэр бүх зүйл тэр хаврынхаараа гацчихсан. Намар нь батлагдаж чадаагүй. Одоо энэ хавар батлагдах болов уу гэж найдаж байна. Үндсэн концепц, төслүүд нь бэлэн байгаа шүү дээ. Асуудал нь УИХ ажлаа хийх эсэх дээр л байна. Шулуухан хэлэхэд, өнгөрсөн жилийн долоо, наймдугаар сар улс төрийн хэрүүл, тэмцэл болоод дууссан. Энэ хавар бас тэгэх вий гэсэн айдас байна. Бидний хувьд нэг л зүйл чухал. Бизнесийн орчинд хийх гэж байгаа системийн өөрчлөлтүүдийг л баталж өгөөсэй. Дараа нь УИХ тарна уу, үгүй юу, тэр хамаагүй.

Бизнесийнхэнд хамгийн хэрэгтэй зүйл бол хямд мөнгө. Гэвч зээлийн хүү маш өндөр байна

► **Мэдээж бүх л хуулийн төсөл чухал байх. Гэхдээ та танхимын Ерөнхийлөгчийн хувиар аль аль хуулийн төслийг илүү чухалчилж байна вэ? Чуулганыг аль төсөл дээр илүү шийдтэй байгаасай гэж хүсэж байна?**

Нэгдүгээрт, Нийгмийн даатгалын хууль, хоёрдугаарт, Татварын багц хууль, гуравдугаарт, Хөрөнгө оруулалтын тухай хууль. Энэ гурван хууль дээр маш их хүлээлттэй байна. Мөн Арилжааны хуулийг нэмж дурдъя. Энэ хуулиар худалдаа, бизнесийн харилцааг бүхэлд нь зохицуулна. Уг нь Иргэний хуулийн нэг том бүлэг байх ёстой салбар юм. Иргэний хуульд гэрээ хэлцлийн хэсэг байдаг. Түүн дотор арилжааны харилцааг илүү системтэйгээр оруулах шаардлагатай. Дээр нь МҮХАҮТ-ын хууль орж ирнэ. Одоо гурав дахь удаагаа хэлэлцэгдэх гэж байна. 1995 онд батлагдаж, 1996 онд шинэчлэгдсэн хууль.

Социализмын үед Худалдааны яамны харьяа агентлаг байсан манай байгууллага сүүлийн 30 жилд жинхэнэ утгаараа бие даасан институц болж төлөвшсөн нь хамгийн чухал. Үүнд С.Дэмбэрэл даргын үүрэг маш их бий. Тэрбээр танхимыг 16 жил удирдаж институцийн түвшинд хүргэсэн. Өнөөдөр Монголд 27 мянган төрийн бус байгууллага байна. Энэ дундаас жинхэнэ институцийн хэмжээнд хүрсэн нь маш цөөн. Тэдгээр цөөн хэдийн нэг нь МҮХАҮТ. Дэлхий даяар ойролцоогоор 4000 гаруй танхим байдаг. Бид энэ сүлжээнд багтаж, олон улсын танхимуудын жишгээр ажиллаж байна. Цаашид энэ амжилтаа бататгаж институцийн хувьд улам бэхжихийг зорьж байна. Тиймдээ ч хуулийн шинэчлэлээ хүлээж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийг олон жил ярилаа. Мөн л ялгаагүй шүүмжлэл дагуулдаг хууль. Таныхаар энэ хуулийн гол алдаа юу вэ?

Хөрөнгө оруулалтын тухай хууль анх 2013 онд батлагдсан. Батлах болсон гол шалтгаан нь “алдарт 17 хувийн өсөлт” асар богино хугацаанд хөөс шиг хагарч орхисонд оршдог. 2013 оны аравдугаар сар гэхэд гадаадын хөрөнгө оруулалт 100 сая ам.доллар болтлоо навс унасан шүү дээ. Алдаагаа эртэл 2013 оноос өмнө баталсан өөр нэг хуультай холбоотой байсан. Тэр хуульд

хөрөнгө оруулагчдын орж болох салбаруудыг хязгаарлагдмал хүрээнд тогтоосон байсан. Ингээд шинэ хууль баталсан.

Гэвч татвартай холбоотой заалтаас болоод бас л “ажилладаггүй хууль” болж хувирсан. Хэрэв 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийгээд, ашиг хүртлээ гэхэд тэр ашгаасаа дахиад хөрөнгө оруулбал татварын хөнгөлөлт эдэлнэ гэсэн агуулгатай заалт байдаг юм. Гэтэл Татварын тухай хуульд үүнтэй уялдсан зохицуулалт байгаагүй учир баталсан хууль нь бэлгэ тэмдэг төдий болж хувирсан. Хөрөнгө оруулалт нэмж татах боломжоо бид өөрсдөө ингэж боомилсон.

Уг нь гадаадын хөрөнгө оруулагчид шинээр орж ирээд нэг удаа хөрөнгө оруулалт хийхээс илүүтэй үүсгэсэн харилцаа холбоондоо үндэслэж дахин дахин хөрөнгө оруулалт хийх хандлагатай байдаг юм.

Нөгөө талаас, хөрөнгө оруулалтын орчин маш их өрсөлдөөнтэй. “Монгол сайхан орон” гээд хэн ч мөнгөө бариад ирэхгүй. Сая бид Төв Азийн хэд хэдэн орноор явж үзсэн. Хөрөнгө оруулалтын хуульдаа Монголд болохгүй гэж хорьсон бүхнийг “болно оо” гээд тусгачихаж. Хөрөнгө оруулагчийн эрхийг маш сайн хамгаалсан байна.

Казахстан л гэхэд 424 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан байна. Энэ нь хууль эрхзүйтэй нь л холбоотой. Хөрөнгө оруулагч хөрөнгөө буцааж татаж болох юм байна, татлаа гэхэд татвар гэх “мангасын агуй”-гаар дамжихгүй юм байна, гомдол маргаан гарахад нутагт нь олон улсын арбитрын систем үйлчлэх юм байна гэх мэт итгэж болох аюулгүй мэдрэмжийг хөрөнгө оруулагчдад өгч байна. Бид нэгэн цагт Төв Азийн орнуудаас илүү явж байсан бол одоо олон үзүүлэлтээр хоцорчихож. Дэд бүтэц, эрчим хүч, тээвэр логистик нь хол тасарчихаж. Хөрөнгө оруулагчид хууль харж орж ирэхээс гадна хатуу дэд бүтэц хардаг. Гэтэл манай дэд бүтцийн хоцрогдол дан манайд гэлтгүй бүс нутгийн хэмжээнд асуудал болчихсон. Одоо цагт дизель зүтгүүртэй, 40 км/ц хурдтай галт тэрэгтэй, нэг чиглэлийн төмөр замтай улс манайхаас өөр бараг байхгүй. Авто замын сүлжээ ч олон улсын стандарт, жишгээс хоцорчихсон. Хөрөнгө оруулалт татъя, гадаад ертөнцтэй хамтаръя гэвэл энэ бүх хүчин зүйлд анхаарах хэрэгтэй. ►

Бид нэгэн цагт Төв Азийн орнуудаас илүү явж байсан бол одоо олон үзүүлэлтээр хоцорчихож

► **Монголын бизнесийн орчныг сайжруулж, бизнес эрхлэгчдийг дэмжихийн тулд өөр ямар бодлогын дэмжлэг хэрэгтэй байна вэ?**

Бидэнд хамгийн түрүүнд хэрэгтэй зүйл бол хямд мөнгө. Өөрөөр хэлбэл, бизнесийн мөнгөний эргэлт боломжийн өртөгтэй байх ёстой. Гэтэл манайд мөнгө маш үнэтэй байна. Банкны зээл доод тал нь 17 хувь байгаа бол ХЗХ, ББСБ-ын зээлийн хүү 30-40 орчимд байгаа. Бизнес жижиг байх тусам илүү өндөр хүүтэй зээл авч, томчууд нь бага хүүтэйг авдаг болсон. Хөгжлийн банкны жишээ байна шүү дээ. Тийм учраас гадаадын банкуудыг оруулж, өрсөлдөөнийг нэмэх шаардлагатай.

Нөгөөтээгүүр, хадгаламжаар өндөр хүү “хүүлдэг” тогтолцоог өөрчлөх шаардлагатай. Хадгаламжийн хүү буураагүй цагт зээлийн хүү буурахгүй. Нэг баримт онцлоход, манай улсад нийт хадгаламжийн 97 хувь нь хадгаламж эзэмшигчдийн гурван хувьд л төвлөрч байгаа. Тэр гурван хувьд багтах хүмүүсийн өгөөжийг бүрдүүлэх гэж улс нийтээрээ зүтгээд байна. Хадгаламжийн хүү өндөр байхаар мөнгөтэй хүн ажил хийх ч хэрэггүй болно. Мөнгөжвөл мөнгөө цоожлоод авъя л гэж бодно. Зах зээлд хямд мөнгө байхгүй учраас цалин, нийгмийн даатгал, татварын зардал дагаад өснө. Бизнес босгох нь бараг эрсдэл болно.

Үүнээс гадна хөдөлмөрийн зах зээл өөрөө “оргилуун” биш байна. Энэ бол бизнесийн орчны бас нэг “чөдөр”. Халамжид тулгуурлан амьдрах хандлага нэмэгдэж, нөгөө талд улс төрчид халамж амлаж, мөнгө тарааж өрсөлддөг болсон. Ийм юм хийвэл өрөнд орно, тийм юм хийвэл олигтой цалин авахгүй гэсэн хандлага урт хугацаанд давамгайлвал чадварлаг боловсон хүчнээ гадагшаа алдана. Багахан орлогоороо амьдраад байя гэсэн бүлгийнх нь бүтээмж буурах аюултай. Төв Азийн орнуудаас нэг зүйл тод харагдсан. Төрийн бодлого нь оновчтой байвал иргэд нь хөдөлмөрч чанараа алддаггүй юм байна. Харин бидэнд хөдөлмөрч чанар байгаа ч өмнөх шигээ хүчтэй биш болж байна. Энэ бол харамсах зүйл мөн.

Гавьяат эдийн засагчийн хувиар та нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн дүгнэх вэ? Энэ асуултаар ярилцлагаа өндөрлөө.

Оны эхэнд миний хэлж байсанчлан 6.8 хувийн



өсөлт бол цэвэр бизнесийнхний хүч. Малчид, тариаланчид, компаниудын хийсэн ажил. Өнгөрсөн жилийн VII, VIII сард улс төрчид хоорондоо хэрэлдээд л сууж байсан. Тэд энэ өсөлтөд ямар ч хамаагүй. Гэтэл эдийн засгийг нуруундаа үүрч яваа компаниудаа бид “ашгийн төлөө хүмүүсийн нэгдэл” гэж хуулиндаа хүртэл маш бүдүүлэг тодорхойлдог. Үнэндээ цалингийн сангийн төлөө нэгдсэн хүмүүсийн нэгдэл юм шүү дээ. 10 хүн байна уу, 100 хүн байна уу ялгаагүй, цалингийн сангаа бүрдүүлэхийн төлөө хамтдаа ажиллаж байгаа хамт олон. Тэднийг дэмжих ёстой атал “ашиг хайгчид” гэж тодорхойлсондоо ч тэр үү, нуруун дээр нь их ачаа овоолж байна. Одоо үүнийг өөрчлөх ёстой.

Дээр нь эдийн засагт гадаад орчны нөлөө чухал. Нүүрс, зэсийн экспорт нэмэгдэж, зэс, алтны үнэ өсөж байна. Гэхдээ энэ өсөлт хүн бүрд жигд хүрэхгүй байна. Хүмүүс харьцангуй бага орлоготой, амьдрал нь хэцүү хэвээрээ л байна. Тийм учраас хөдөлмөрийн үнэлгээг өсгөж, бүтээмжээ нэмэх зайлшгүй шаардлага бий. Үгүй бол бид энэ бүсийнхээ хамгийн ядруу улсуудын нэг болох нь.

Би саяхан Исландад очоод ирлээ. 400 мянган хүнтэй жижиг улс мөртлөө амьдралын өртөг маш өндөр. Гэхдээ цалин өндөр, үйлчилгээ сайтай. Нэг хүнд ногдох орлого нь 100 мянган ам.доллар. Энэ нь өндөр үнэ, өндөр цалин, өндөр чанар гэсэн тэнцвэрийг бүрдүүлж чадсантай холбоотой. Мөн эдийн засгаа хамгаалсан бодлоготой. Манай улс газрын баялгаа ашиглаж байгаа бол ийм түвшинд хүрэх зорилго тавих ёстой. ■

Эдийн засгийг нуруундаа үүрч яваа компаниудаа “ашгийн төлөө хүмүүсийн нэгдэл” гэж хуульдаа бүдүүлгээр тодорхойлдог. “Ашиг хайгчид” гэж тодорхойлсондоо ч тэр үү, нуруун дээр нь их ачаа овооллоо

ШИНЭ ҮЕИЙН ТАНХИМ

Дэлхий даяар худалдаа, аж үйлдвэрийн танхимууд суурь өөрчлөлтийн босгон дээр ирээд байна. “Тамга дардаг байгууллага” гэх уламжлалт ойлголт хуучирч, оронд нь дата, платформ, сүлжээнд суурилсан шинэ үеийн институц бий болж эхэллээ.

“Танхим 5.0”
концепц нь
МҮХАУТ-ыг
цахимжсан
шинэ үеийн
институц
болгоно

Chamber 5.0 гэж юу вэ

Энэхүү шилжилт олон улсын түвшинд Дэлхийн худалдааны танхим (International Chamber of Commerce буюу ICC)-ын гишүүн 100 мянга гаруй байгууллагад хэдийнээ ажиглагдаж эхэлсэн. Уг өөрчлөлтийн учир шалтгааныг судалж үзвэл сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засагт хүч түрэн гарч ирж буй хоёр хүчтэй тренд байгаа нь харагдана. Эхнийх нь технологийн үсрэнгүй хөгжил юм. Бизнес эрхлэгчид ямар нэг үйлчилгээ авахын тулд цаасан материал бүрдүүлж, олон шат дамжлага дамжихыг хүлээхээ больсон. Хоёрдугаарт, байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) шаардлагууд нь бизнесүүдэд бодит шалгуур болж хувираад байна.

МҮХАУТ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа энэ талаар “Сүүлийн жилүүдэд танхимууд үйл ажиллагаа, бүтэц, загвараа шинэчлэх буюу ‘редизайн’ хийх чиглэлд шилжиж байна” хэмээн онцолсон. Өөрөөр хэлбэл, худалдаа, аж үйлдвэрийн танхимууд нь зөвхөн үйлчилгээ үзүүлэгч биш харин экосистемийн зохион байгуулагч, менежер болох шаардлага үүсээд байна.

Энэхүү чиг хандлагын хүрээнд “Chamber 5.0” хэмээх концепц бий болжээ. Энэ нь танхимууд дижитал шилжилтийг хэрхэн хийх, цахим танхимын үйлчилгээг хэрхэн хөгжүүлэх, мөн бизнесүүдийн хамтын ажиллагааг илүү нягт уялдуулахад чиглэж байгаа юм. Уг концепц нь нийт таван үндсэн ойлголтыг агуулж байна.

Үүнд,

Ухаалаг – Дижитал платформ, хиймэл оюун ухаанд суурилсан шийдэл нэвтрүүлэх

Холбогдсон – Гадаад дотоодод дата, туршлага, үйлчилгээний сүлжээг бий болгох



Инновацлаг, холбогдсон – Хүний нөөцийн чадварын хөгжлийг дэмжих, “Chamber Academy”-ийг бий болгох

Тогтвортой – БОНЗ, ногоон шилжилтийн стандартыг нэвтрүүлэхэд нь бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх

Итгэлцэлд тулгуурласан – Ил тод, дата суурьтай засаглалыг хөгжүүлж, итгэл төрүүлэхүйц байх Эдгээр нь ойлголтууд нь нийлээд худалдаа, аж үйлдвэрийн танхимуудыг “оффис” төвт байгууллага бус биет бөгөөд дижитал “платформ” болгож хувиргах юм.

Монгол Улсад энэ өөрчлөлт бодит ажил хэрэг болоход ойрхон ирээд байна. Хамгийн гол нь энэ бол жирийн нэг дижитал шилжилт, цахимжуулалтын асуудал бус харин МҮХАУТ, бизнесийн орчинд гүйцэтгэх үүрэг роль, төр-хувийн хэвшлийн харилцааны архитектурыг бүхэлд нь дахин зураглах оролдлого гэдгийг онцлох нь зүйтэй.

Танхим хэрхэн цахимжих вэ

МҮХАУТ үйл ажиллагаа болон үйлчилгээг цахимжуулах хүрээнд хуулийн этгээдийн бүртгэл, мөн 300 гаруй төрлийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэгтгэн бизнес эрхлэгч, гишүүддээ илүү хялбар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр зорьж байна. Өнөөдрийн байдлаар зөвшөөрөл олголт ▶



► нь бичиг цаасанд суурилсан, олон шат дамжлагатай, хүн хоорондын харилцаанаас хамааралтай хэвээр байгаа. Цахим шилжилт нь эдгээр асуудлыг бууруулах нэг үндсэн шийдэл юм. Энэ хүрээнд МҮХАҮТ нь гарал үүслийн гэрчилгээ, давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ зэрэг үндсэн болон уламжлалт үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэхэд бэлэн болсон. Мөн цахим платформоор дамжуулан дэлхийн танхимуудтай холбогдох, тэдгээрийн ноу-хау, бүтээгдэхүүн, үйлчилгээ, туршлагыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлж байна. Энэ зорилгоор танхим нь технологийн бэлэн байдлаа хангах, чадавхыг бэхжүүлэх зорилгоор Европын холбоо болон олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй.

М.Сарандаваа энэ өөрчлөлтийн талаар “Танхимын хөгжлийн хувьд дижитал шилжилтийг бүрэн нутагшуулах нь чухал ач холбогдолтой. Энэ нь бизнесийн орчинд үүсдэг хүнд суртал, давхардсан шаардлага, үл ойлголцлыг бууруулж, улмаар итгэлцлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж онцолсон.

Дижитал шилжилтийн хүрээнд авч үзэх ёстой нэг чухал чиглэл бол зөвшөөрлийн тогтолцоо юм. Одоогийн байдлаар бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлүүдийг

аймаг, дүүрэг, хороо зэрэг төрийн байгууллагууд олгож байна. Жишээлбэл, зоогийн газар, үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарь, үсчин, кофе шоп зэрэг үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл зэрэг нь төрийн олон шат дамжлагаар дамжин шийдэгддэг. Мөн зөвшөөрөл бүрийг дагалдсан 3000 гаруй журам үйлчилж байгааг дурдах хэрэгтэй. Энэ нь мэдээж хүнд суртал, төрийн үйлчилгээний шат дамжлага нэмэгдэх, зарим тохиолдолд сөрөг практик үүсэх эрсдэлийг дагуулдаг. Иймээс шинэ зохицуулалтын хүрээнд тусгай зөвшөөрөл шаардахгүй зөвшөөрлүүдийг МҮХАҮТ-д төвлөрүүлж, цахимаар олгодог болгох шийдлийг холбогдох хуулиудад тусгах ажээ. Сонирхуулахад, нийт зөвшөөрлийн 60-70 орчим хувь нь үйл ажиллагаа эхлүүлэх, зогсоох зэрэгтэй холбоотой энгийн, журамласан зөвшөөрлүүд байдаг. Иймээс хууль, эрхзүйн шинэчлэлийн хүрээнд эхний ээлжид энгийн, тусгай зөвшөөрөл шаарддаггүй зөвшөөрлүүдийг МҮХАҮТ-д шилжүүлж, цахим хэлбэрээр олгох юм. Харин уул уурхай, барилга, хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад мэргэжлийн салбарын тусгай зөвшөөрлүүдийг салбарын онцлог, мэргэжлийн шаардлагаас шалтгаалан холбогдох байгууллагууд олгох зохицуулалт хэвээр үргэлжилнэ. Зөвшөөрөл олголтыг танхим руу шилжүүлэхтэй холбогдуулж, одоогоор бэлэн байдлын судалгаа, танхим болон зарим төрийн бус байгууллагын хүрээнд туршилтын болон суурь судалгааг тус тус хийжээ.

Энэхүү үзэл баримтлал, шинэчлэлийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд 2026 оны УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөөд байна.

Бизнесийн орчинд зөвшөөрөл олголтын энэхүү өөрчлөлтийг хүний нөөцөд суурилсан уламжлалт загвараас илүү технологид суурилсан, автоматжуулалт, цахим системд тулгуурласан байдлаар хэрэгжүүлнэ. Ингэснээр орон тоо, бичиг цаасны ачаалал нэмэгдэх, шат шатанд дараалал, ачаалал үүсэх зэрэг эрсдэл эрс буурах юм.

Өөрөөр хэлбэл, “Танхим 5.0” хэмээх концепц нь Монголын бизнесийн төлөөллийн гол байгууллага болох МҮХАҮТ-ыг цахимжсан шинэ үеийн институт болох өөрчлөлтийн луужин болоод зогсохгүй бизнесийн орчныг ч шинэчлэх, төр, хувийн хэвшлийн хоорондын итгэлцлийг бодитоор нэмэгдүүлэх томоохон реформ болох учиртай. ■

Тусгай зөвшөөрөл шаардахгүй зөвшөөрлүүдийг МҮХАҮТ-д төвлөрүүлж, цахимаар олгодог болгох шийдлийг холбогдох хуулиудад тусгах ажээ



"ЧӨДӨРТЭЙ МОРЬ"-ОО

МҮХАҮТ бодлогын өмгөөллөөр дамжуулан бизнесийнхний "чөдөр", "тушаа"-г тайлж, эдийн засгийн хөгжлийг дараагийн шатанд түүчээлэхээ мэдэгдлээ.

ЧӨЛӨӨЛЬЕ

Хууль
давсан
журам
хамгийн
том саад

Монголчууд бид чөлөөт зах зээлд хөл тавиад 30 гаруй жил болсон ч бизнесийн орчин зах зээлийн зарчмаар бус, хэтийдсэн дүрэм журам, далд давуу эрхийн сүлжээгээр зохицуулагдаж байна. Энэ бол хэнд ч ил үнэн. Тиймээс МҮХАҮТ 2026 оныг "бодлогын өмгөөллийн жил" хэмээн зарлаж, чөлөөт зах зээл дэх "чөдөртэй морь"-ийг чөлөөлөхөөр зорьж байна. Бодлогын өмгөөлөл бол асуудлаа шударгаар тодорхойлж, түүний шийдлийг төр засгийн түвшинд хүлээн зөвшөөрүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, "залруулгын механизм" гэж тодорхойлж болно.

Монголын бизнесийн орчинд "залруулга" хийх ёстойг илтгэдэг хэд хэдэн хүчин зүйл бий. Үүнээс хамгийн тод нь бизнес болоод улс төрийн хэт ойрын холбоо юм. Тэдний дотносол "давуу эрхийн эдийн засаг"-ийг бий болгосон. Эндээс улс төрийн холбоогоор давуу тал олж авдаг жишиг хаанаас эхэлсэн бэ гэх асуулт урган гарна. Хариулт нь тодорхой. Бүх зүйл зөвшөөрөл, лиценз хөөцөлдөхтэй зэрэгцэн өрнөж эхэлдэг.

Зөвшөөрлийн тогтолцоо

Монголын бизнесийн орчны хамгийн эмзэг цэг бол зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олж авах үйл явц юм. Жижиг бизнес эхлүүлэх, мега төсөл хэрэгжүүлэхийн аль алинд үй олон зөвшөөрөл хүснэ. Зарим нь давхацна, зарим нь бүр огт хэрэггүй ч байж болохоор. Ямартай ч зөвшөөрүүлэх шаардлагатай. Гэвч хамгийн ноцтой нь зөвшөөрөл авах өгөх нь авлигын суурь болж, шударга өрсөлдөөнийг алдагдуулдаг хаалт болж хувирсан. Одоогоор Монгол Улсад 250 төрлийн тусгай зөвшөөрөл, 121 төрлийн энгийн зөвшөөрлийг олгоход хуулиар "шүүгээд" зогсохгүй хуультай дүйх журмыг давхардуулан тулгаж байна. Мөн зөвшөөрөл авахын тулд 9-33 төрлийн баримт бичиг бүрдүүлж, 39-138 шат дамжлага дамжин 21-100 хоног хүлээж байж зөвшөөрлийн хариугаа авч байна.

Тиймээс үйлчилгээний салбарын зарим зөвшөөрлийг төр биш, мэргэжлийн холбоод олгодог болох нь хамгийн оновчтой гарц юм. ▶

► Энэ зохицуулалт Худалдаа аж үйлдвэрийн танхимын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд суусан гол концепцуудын нэг. Хэрэв МҮХАҮТ тодорхой зөвшөөрлүүдийг ил тод, цахим хэлбэрээр олгодог болчихвол орон нутгийн удирдлага, аль нэг нам эвслийн далбаан доорх хэн нэгэн “зөвшөөрлийн процесс”-т хуруугаа дүрэх шаардлагагүй болно.

Журамжсан эдийн засаг

Бизнес эрхлэгчдээс зөвшөөрлийн дараах том саад юу вэ гэж асуувал тэд зохицуулалтын “ширэнгэн ой” болсон журмуудыг нэрлэнэ. МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав “Монгол Улсад 930 гаруй хууль үйлчилж байхад, 2768 журмаар бизнес эрхлэгчдийг давхардуулан дарлаж байна” гэсэн юм. Гэхдээ асуудал нь тоо биш, тодорхойгүй байдал. Яамдын гаргасан хуулиас илүү “эрх дархтай” журмууд үргэлж асуултын тэмдэг дагуулдаг. Зарим нь бүр өөрсдөдөө ашигтай зүгт нөхцөл байдлыг эргүүлсэн байдаг. Үр дүнд нь хөрөнгө оруулалт хумигдана, жижиг, дунд бизнесүүд зах зээлээс шахагдана. Том компаниуд төртэйгээ үзэлцэнэ, стратеги төлөвлөлт нь байнгын гацаанд орно. Иймд танхим бодлогын өмгөөллөөр дамжуулж “журамжсан эдийн засаг”-ийг хүлээсээс нь задлах “амбиц” тээж байна.

Төрөөс тогтоосон төлбөр

Монголын зарим салбарт зах зээлийн үнэ бус төр засгаас тогтоосон “төлбөрийн хязгаарлалт”-ууд тоглоомын дүрмийг тогтоож байна. Ялангуяа эрчим хүчний салбар энэ дүрмийн хамгийн том хохирогч. Чөлөөт зах зээлийн дүрмээр бол эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр үнэ тогтох ёстой. Гэтэл улс төрийн

шийдвэрээр төлбөр тогтож байгаа нь хөрөнгө оруулагчдыг бараг л цочоодог. Эрчим хүчний төсөл дээр гаднын хөрөнгө оруулагчид орж ирдэггүй нь ч үүнтэй холбоотой.

Үүгээр барахгүй “хохилогч салбар” татаасаар амьдардаг бүтэц болон хувирч, муу юм бүхний эхэнд цоллуулдаг. Сонгуулийн амлалтын “шидэт дохиур” ч болж болно. Аль ч тохиолдолд тэр салбар эмгэнэлтэй хувь заяагаар замнана.

Хэрэв эрчим хүчний салбарт бодит үнэ тогтвол юу болох вэ? Төсөөлөхийг оролдоё. Хэрэв тийм зүйл болбол энэ талбарт хувийн хэвшлүүд зоригтойгоор хөл тавьж, янз бүрийн хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэрүүд нэмэгдэнэ. Гэтэл тоглоомын дүрэм нэгэнт ийм биш учраас төр өөрөө төсөл сэдэж, төслөө санхүүжүүлж, бүтээн байгуулалтаа хүртэл өөрсдөө хийхийг оролдож байна. Төлөөсөнд нь урт нас, удаан түүхтэй, зардал өндөр төслүүд олон нийтийн хүлээлтийн нэг хэсэг болон хувирч, салбарын “зовлон” мөнхөд үргэлжилж байна.

Дэлхийн танхимуудын туршлага


Дэлхийн ихэнх оронд худалдаа, аж үйлдвэрийн танхимууд бодлогын өмгөөллийн гол институц байдаг. АНУ-ын Худалдааны танхим (U.S. Chamber of Commerce) гэхэд, Татварын бодлогын өөрчлөлтөд идэвхтэй оролцдог. Шүүхийн түвшинд хүртэл бодлогын байр сууриа хамгаалдаг.

Харин Германд аж үйлдвэрийн танхимууд (ИНК) салбарын стандарт тогтоох, хувийн хэвшлийн бүртгэлийг хийх, гарааны бизнесыг бойжуулах, Засгийн газарт бодлогын зөвлөмж өгөхөд идэвхтэй оролцдог. Сингапурын бизнесийн холбоод ч мөн бодлогын өмгөөллийн тал дээр ихээхэн үр дүнд хүрч чадсан. Тухайлбал, зөвшөөрлийг цахимжуулах, бизнесийн маргааныг шуурхай шийдвэрлэх, бизнес эхлүүлэх хугацааг багасгах, төр-бизнесийн шууд харилцааны үр дүнд суурилсан платформ бий болгоход гол үүрэг гүйцэтгэсэн. Манай улсын эдийн засаг жижиг. Жижиг тусмаа зөв, буруу бодлогын үр нөлөө шууд тусна. Тиймээс дэлхийн туршлагыг дагаж, тоглоомын дүрмийг тогтооход танхимын оролцоог бэхжүүлэх нь чухал. Хувийн хэвшлийнхний зовлон жаргалыг хамгийн сайн ойлгодог институцийг бодлогын гал тогоонд ойр байлгавал бизнесийн орчинд гэрэл асах нь дамжиггүй. ■

Бодлогын өмгөөлөл бол асуудлаа шударгаар тодорхойлж, түүний шийдлийг төр засгийн түвшинд хүлээн зөвшөөрүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа юм

Бизнесийн сорилтууд

Бизнес эрхлэгчдийн үнэлгээ, хувиар



Эх сурвалж: “Хүнд суртлын индекс ба өртөг” судалгаа, 2025 он



“Жүр үр”
компани
10,000 м.кв
талбай
бүхий шинэ
үйлдвэрийн
байр
ашиглалтад
оруулав

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ҮР ДҮНД 53 ҮЙЛДВЭР АШИГЛАЛТАД ОРОВ

Төрийн бодлого хэрэгтэй цагтаа, зөв зүйлд хүрэх нь богино хугацаанд ямар том амжилтыг дагуулж болдгийг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнөөс харж болохоор байна. Энэхүү хөдөлгөөний хүрээнд 2500 гаруй аж ахуйн нэгж 1.26 их наяд төгрөгийн зээл авч үйлдвэрээ өргөжүүлж, шинээр барьж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг нь сайжруулж бүр цаашлаад экспортод гаргах тухай өөдрөг мөрөөдөлтэй болжээ. Энэ бол 3.5 жилийн дотор гарсан үр дүн. Энэ хөдөлгөөн амжилттай хэрэгжихэд Ерөнхийлөгчийн баг хамт олон,

тэр дундаа “Хүнсний хувьсгал” төрийн бус байгууллага хичээл зүтгэл гарган ажилласныг дурдах нь зүйтэй.

Мөн гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодынхоо хэрэгцээг хангаж, улмаар экспортлогч орон болъё гэдэг зорилт тавьсан. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хөтөлбөрт хамрагдаж амжилттай ажиллаж байгаа олон үйлдвэрээр орж, үйл ажиллагаатай нь танилцав. Тэд үнэхээр хийе, бүтээе, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэе гэсэн чин сэтгэлээр хичээн зүтгэж ажиллаж байна. Тэрбээр өндөг ▶



► үйлдвэрлэгч “Түмэн шувуут”, талх нарийн боов, бялууны “Жүр үр”, “Монос хүнс”-ээс эхлээд жижиг, дунд аж ахуйн нэгж, “Eden”, “Өгөөмж Архад” талх нарийн боовны үйлдвэрээр орж танилцсан юм. Тэд хийж бүтээх эрмэлзэл, нүдэнд нь гал, хүсэл тэмүүлэл дүүрэн харагдана. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх анх удаагаа хүнсний асуудлыг үндэсний хэмжээнд аваачиж, том хөдөлгөөн өрнүүлсэн нь хэдхэн жилийн дотор үр дүнгээ өгсөн нь ийн харагдаж байна.

“Түмэн шувуут” компани гэхэд л урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл авч, өнгөрсөн онд “Түмэн шувуут-2” үйлдвэрээ ашиглалтад оруулан, дараагийн үйлдвэрээ барьж байна. Энэ онд 170 сая, ирэх жил 250 сая ширхэг өндөг үйлдвэрлэх бөгөөд энэ нь энэ чиглэлийн бусад аж ахуйн нэгжүүд нийлээд дотоодын зах зээлийн 75 хувийг хангах чадамжтай. Харин 2026 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж 100 хувь хангах зорилт тавьж байна.

“Монос хүнс” компани 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл авчээ. Ингэснээр дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулж, хүнсний агуулахаа өргөтгөхийн зэрэгцээ нийслэлийн зүүн бүсэд шинэ агуулахын бүтээн байгуулалтыг эхлүүлж, хүүхдэд зориулсан жимсний нухашны тоног

төхөөрөмжөө шинэчилжээ. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал гурав дахин нэмэгдэж, биет хэмжээ 96 хувь, борлуулалтын орлого 2022 онтой харьцуулбал 68 хувиар буюу 19 тэрбум төгрөгөөр өссөн байна.

“Жүр үр” компани бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, 10,000 м.кв талбай бүхий шинэ үйлдвэрийн байраа ашиглалтад оруулан хүчин чадлаа нэмэгдүүлжээ. Харин жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг “Eden” компани үйлдвэрийн хүчин чадлаа 3.5 дахин нэмжээ. Мөн үйлдвэрлэл нь шинэ шатанд гарч долоон брэндийн 68 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн нэмэгдэж, үйлдвэрлэлийн хэмжээ нь 1489 тонн буюу 89 хувиар өсжээ. Энэ өсөлтийг дагаад улсад төлөх татвар, НӨАТ, НДШ 2-3 дахин өссөн байна.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголд амжилттай хэрэгжиж байгаа олон улсын төслүүд ч бий. Манай баялаг бүтээгчид ч зогсолтгүй ажиллаж байна. Төр засгаас сайн дэмжиж байна. Арилжааны 10 банкаар бага хүүтэй зээл олгож, татаасыг нь улсаас хариуцаж байна. Дээрээс нь зээлийн батлан даалтын сангаас аж ахуйн нэгжийн зээлийг нь батлан дааж байна. Тэд хамтдаа энэ бүгдийг бүтээж байна. ■

Арилжааны 10 банкаар бага хүүтэй зээл олгож татаасыг нь улсаас хариуцаж байна

ХҮНСНИЙ
ҮЙЛДВЭР

53-ААР
НЭМЭГДЭВ

884 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР
2022 он

Мал төхөөрөх **102**
Мах боловсруулах **76**
Сүү боловсруулах **83**
Гурил, гурилан бүтээгдэхүүн **437**
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн **16**
Давс **8**
Шингэн хүнс **162**

937 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР
2025.III

Мал төхөөрөх **112**,
Мах боловсруулах **83**
Сүү боловсруулах **93**
Гурил, гурилан бүтээгдэхүүн **452**
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн **19**
Давс **6**
Шингэн хүнс **165**
Бусад **7**



ХЯЗГААРЛАГДМАЛ ХҮРТЭЭМЖИЙГ

ТЭЛЭХ СТРАТЕГИ

Дэлхийн хүнсний үйлдвэрлэл сүүлийн 30 жилд 50-60 хувиар өссөн ч хүртээмжийн асуудал, хоол хүнсний чанарын ялгаа асар их байна.

Аймаг, бүс бүр хүнсний брэнд бүтээг-дэхүүнтэй, хүнсний шилдэг хоршоотой болно

Дэлхий дахинаа хүнсний үйлдвэрлэл сүүлийн 30 жилд 50-60 хувиар өссөн ч хүртээмжийн асуудал, хоол хүнсний чанарын ялгаа асар их болжээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) мэдээлснээр хоёр тэрбум хүн шим тэжээлийн дутагдалтай буюу тэжээллэг хоол хүнс хангалттай авч чадахгүй байна. Түүнчлэн вирус, нян, шимэгч, хүнд металл, пестицид зэрэг бохирдуулагчтай хоол хүнс нь 200 гаруй төрлийн өвчний шалтгаан болж байна гэдгийг 2023-2024 оны тайландаа дурджээ.

Монгол Улсын хувьд хөдөө орон нутагт хүнсний үйлдвэрлэл дотоодын хэрэгцээг хангах гол эх үүсвэр боловч дэд бүтэц, хадгалалт, түгээлтийн сүлжээ муу хөгжсөн

зэргээс шалтгаалан хүнсний хүртээмж хязгаарлагдмал хэвээр байна. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих төдийгүй, хүн амын эрүүл мэнд, аюулгүй органик хоол, хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын чухал алхам болов. Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулан ард иргэддээ үр өгөөжтэй өөрчлөлтүүдийг авчирна гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх зарласан билээ.

Үүний үр дүнд өнгөрсөн жил хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодоос хангаж ▶

► чадсан юм. Мөн газар тариалангийн салбарт олгосон зээлийн үр дүнд нийт зоорины багтаамж 2021 оны суурь түвшний үзүүлэлтээр 230 мянган тонн байсан бол 2024 онд 292.2 мянган тонн болж өссөн. Махны экспортын орлогыг 2022 оны дүнтэй харьцуулахад 50 сая ам.доллараас 285.4 сая ам.доллар болж 71.1 хувиар өсжээ.

Хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд 21 аймгийн хүнсний үйлдвэрлэл нэн чухал. Тиймээс бүс, орон нутгийн онцлогт тулгуурлан, хүнсний бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хөгжүүлэх, дэмжих чиглэлд бодитой ажлууд хийж байна.

Өндөгний хэрэгцээгээ өөрсдөө

Дэлхийн хэмжээнд нэг хүнд ногдох өндөгний хэрэглээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж, дундаж хэрэглээ жилд ойролцоогоор 10 кг орчим болсон бөгөөд энэ нь хүн амын хоол тэжээлийн чанарын өсөлтийг харуулж буй юм. Манай улсад өндөгний үйлдвэрлэл хөгжих нь хүнсний аюулгүй байдлыг хангах, импортын хамаарлыг багасгах, орон нутгийн эдийн засгийг дэмжих малчид, фермерүүдийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох ач холбогдолтой. 2020 оноос өмнө өндөгний есөн үйлдвэр үйл ажиллагаа явуулж 50-иас дээш хувийг импортоор хангадаг байв. Харин “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнд хөдөө, орон нутагт өндөгний үйлдвэрлэл нэмэгдэж байна. **ДОРНОГОВЬ** аймгийн “Мөрөөдлийн говь” ХХК “Өдөр бүр шинэ өндөг” гэсэн уриатай говь нутгийн иргэдийн өндөгний хэрэгцээг хангах автомат үйлдвэр нээн ажиллуулж буй. Тус компанийн “Шанд эгг” өндөгний ферм 2021 оны аравдугаар сард анхны дэгдээхэйгээ хүлээн авч 2022 оны гуравдугаар сард эхний өндгөө зах зээлд гаргаж эхэлсэн. Тус үйлдвэр 30 гаруй мянган тахиатай, орон нутгийн өндөгний хэрэгцээний 60 гаруй хувийг хангадаг. Үйлдвэрийн дарга Э.Батхуяг “Цаашдаа орон нутгаа 100 хувь хангаж Улаанбаатар болон хөрш зэргэлдээх аймгуудад нийлүүлэх зорилготой” хэмээн ярилаа.

БАЯНХОНГОР аймгийн Баянхонгор сумын “Агин өндөг”-ний үйлдвэр нь хөнгөлөлттэй зээлд хамрагдан хоёр жилийн дотор 2500 тахиаг 12 мянга болгон үржүүлж үйлдвэрээ хамгийн сүүлийн үеийн, олон улсын стандартад нийцсэн бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглож хүчин чадлаа 3-4 дахин нэмэгдүүлжээ. Ингэснээр Баянхонгор аймгийн өндөгний

хэрэгцээг 100 хувь хангадаг болж, илүү гарснаа Өвөрхангай аймагт нийлүүлж эхэлжээ.

ХЭНТИЙ аймгийн Чингис хотод “Хэрлэн өндөг”-ний үйлдвэр шинээр үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Тус үйлдвэр одоогийн байдлаар 2000 тахиатай, өдөрт 1900-2000 ширхэг шинэхэн өндгийг аймгийнхаа иргэдийн гарт хүргэж байна. Энэхүү үйлдвэрийг Улаанбаатар хотоос шилжиж ирсэн залуу гэр бүл 2023 онд байгуулжээ. Орон нутгийн зүгээс үйлдвэр байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн нь тэдэнд томоохон дэмжлэг болсон байна.

Ийн хөдөө, орон нутгийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд эрэлт ихтэй зах зээлд хөл тавьснаар өнөөдөр монголчууд өндөгний нийт хэрэглээнийхээ 80 орчим хувийг дотоодоосоо хангадаг болжээ.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Болд “Засгийн газрын сайн бодлогын дүнд аж ахуй нэгжүүд зээлд хамрагдаж, үйл ажиллагаагаа өргөжүүлж шинээр 20 гаруй шувууны аж ахуйн эрхлэгч компани нэмэгдсэнээр дотоодын өндөгний хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдсэн. Цаашид өндөгний хэрэглээ 650 сая ширхэгт хүрэх тооцоо бий” хэмээн ярьсан.

Өндөгний бизнес эрхлэгчид тариаланчдын улаан буудайг худалдан авдаг. Энэ жил 60 мянган тонн улаан буудай худалдаж авах төлөвлөгөөтэй аж. Ирэх хоёр жилд гурван сая шувуутай болж, дотоодын өндөгний хэрэгцээг бүрэн хангахаас гадна малын тэжээл үйлдвэрлэл, газар тариалангийн кластер бизнес хөгжүүлэх боломж бүрдүүлнэ.

Хөдөө орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь зөвхөн хүртээмжийг сайжруулдаг төдийгүй эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлдэг. Хөдөө аж ахуйн салбарын орлого нэмэгдсэнээр орон нутгийн ажилгүйдэл буурч, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих замаар орон нутгийн хөгжлийг түргэтгэнэ. Мөн дотоодын хүнсний үйлдвэрлэл нэмэгдэх нь импортыг орлох, валютын урсгалыг багасгах замаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.

Хөдөөгийн хөрсөнд соёолсон “Хүнсний хувьсгал”

ДОРНОД аймаг хамгаалагдсан хөрсний тариалалт, хүнсний нарийн ногооны нэр төрөл, тариалалтыг нэмэгдүүлэх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг өсгөх, хүн амыг шинэ

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Архангай аймгийн 47 аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагджээ

ХӨДӨӨ АЖ АХУЙН АГРОПАРК БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ



**ХАА-н агропарк нь үйлдвэр, фермерүүд, нөхөрлөл, хоршоод, аж ахуйнуудыг дэмжсэн кластер бий болгоход чиглэнэ.

Эх сурвалж: ХХААХҮЯ

- ▶ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах, өрх бүр хашаандаа хүнсний ногоо тариалах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Арван мянган хүлэмж” төслийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хүнсний ногоо тариалан эрхлэгчдэд өнгөрсөн жил 311, энэ жил 400 хүлэмжийг олгосон. Цаашид аймгийн нийт айл өрхийн 50 хүртэлх хувь буюу хоёр өрх тутмын нэг нь хүлэмжтэй болох зорилт тавьжээ. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймгаас санаачлан хэрэгжүүлж буй “Шинэ хөдөө” төслийн хүрээнд тус аймгийн Иххэт суманд нийт 25 хүлэмж, газар тариаланд ашиглах иж бүрэн трактор, 1.3 тоннын усны нөөцийн сав олгожээ.
- БУЛГАН** аймаг ДНБ-ий 60 хувийг хөдөө аж ахуйн салбараас бүрдүүлдэг. 2024 онд мал аж ахуйн салбараас 273.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлжээ. Хүнсний хувьсгалын хүрээнд

олгож буй хөнгөлөлттэй зээлд тус аймгийн 14 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан дотоодынхоо мах, махан бүтээгдэхүүн болон төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлж чаджээ. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Булган аймагт хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх Үйлдвэр технологийн парк байгуулах бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан мах, сүү сүүн бүтээгдэхүүнээр Хойд бүсийн иргэдийг хангахын зэрэгцээ түүний дагалдах баялаг арьс шир боловсруулах, ноос угаах зэрэг үйлдвэрийг барихаар төлөвлөөд буй.

ДОРНОГОВЬ аймагт хөнгөлөлттэй зээлд найман сумын 38 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсанаар хамгаалагдсан хөрсний тариалалтыг 7600 м.кв-аар, хүнсний ногооны зоорины хангамжийг 30.4 хувь, төмс, хүнсний ногооны хоёр хувиар нэмэгдүүлсэн байна. Аймгийнхаа махны хэрэгцээг 100, сүүний 76, гурилан бүтээгдэхүүний 6.6, төмс хүнсний ногооны хангамжийн 25, өндөгний 73 хувийг орон нутгаасаа тус тус хангаж байна.

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар төмс, хүнсний ногоог хадгалах зориулалттай ▶

▶ 305 мянган тонн хүчин чадал бүхий 5989 зоорь бий. Гэсэн хэдий ч хүн амын хүнсний ногоо, төмсний хэрэглээ болон хураан авч буй ургацын хэмжээг харьцуулахад нэмэлтээр 170 мянган тонн багтаамжтай зоорь, агуулах шаардлагатай гэсэн тооцооллыг салбарын яам гаргасан.

ХӨВСГӨЛ аймаг төмс, хүнсний ногооны тариалалт, ургацыг нэмэгдүүлж, хадгалж нөөцлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор 500 тоннын хүчин чадалтай механикжсан хоёр зоорь ашиглалтад оруулжээ. Мөн 2030 он хүртэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн таван хувийг органик баталгаажуулалтад хамруулахаар зорьж буй. Ойрын ирээдүйд органик мах махан бүтээгдэхүүн экспортлогч аймаг болохыг зорьж, малаа бүртгэлжүүлэх, малчдаа чадавхжуулах, малын эрүүл бүсээ нэмэх зорилт тавьжээ.

Харин энэ оны улсын төсөвт 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тусгасан бөгөөд Сэлэнгэ аймгийн Орхон, Мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн суманд нэг загвар, нэг төсвөөр төмс, хүнсний ногооны 200, 500 тонн багтаамжтай агуулахын барилга барьж байна. Эдгээр агуулахыг ашиглалтад оруулснаар 2800 тонн багтаамжтай, жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой механикжсан хөргүүртэй хадгалах орчин шинээр бүрдэх юм. Ингэснээр дээрх сумын ногоочид ургацаа улирал харгалзахгүй хадгалж, борлуулахаас гадна хүнсний ногооны хадгалалт, ангилалт, савлалт, нэмүү өртөг шингээх үйл ажиллагаанд дэвшил гарах боломжтой юм.

Завхан аймгийн хувьд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Улаан хальст саримс”-ны тариалалтыг орон нутагтаа өргөжүүлж, нутгийн брэнд бий болгожээ. Саримсны үрийн сан байгуулж, улаан хальст саримсыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тарьж ургуулж байна. Цаашлаад хүн амын хэрэгцээт саримсны хангамжийг нэмэгдүүлэх, улмаар гадаадад экспортлох зорилт тавьжээ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнд хамааралтай, үр дүнтэй хэрэгжиж буй төслийн нэг нь ХХААХҮЯ, Азийн хөгжлийн банк (ADB), Ядуурлыг бууруулах Япон сангийн хамтарсан “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй”-г нэрлэж болно.

2020 онд эхэлсэн уг төсөл зургаан жилийн хугацаатай хэрэгжиж байгаа бөгөөд уур

амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний ногооны хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн орлогыг өсгөх зорилготой.

Монгол Улсад нийт тариалангийн талбайн дөнгөж 10 орчим хувь нь усалгаатай. Энэ нь байгаль, цаг уурын нөлөөнд ургац тогтворгүй байх гол шалтгаан болж ирсэн. Иймд уг төсөл нь усалгааны дэд бүтцийг шинэчлэх замаар хөдөө орон нутгийн ногоочдыг байнгын орлого, тогтвортой ургацтай болгох чухал алхам юм.

Төслийн хүрээнд дараах аймаг, сумдын услалтын системийг сэргээн засварлах, шинэчлэх ажлыг хийж байна.

- **Ховд аймаг** – Алтай сумын Боомын ам
- **Говь-Алтай аймаг** – Жаргалан сумын Цахир, Халиун сумын Ёлтон
- **Завхан аймаг** – Улиастай сумын Ногоон хашаа, Тэлмэн сумын Хүрэн тал
- **Баян-Өлгий аймаг** – Баяннуур сумын Цул улаан, Сагсай сумын Улаандэл
- **Сэлэнгэ аймаг** – Сант сумын Ивэн гол
- **Төв аймаг** – Батсүмбэр сумын Сөгнөгөр
- **Хэнтий аймаг** – Хэрлэн сумын Дулааны тал

Энэ оны аравдугаар сарын байдлаар долоон услалтын системийн барилга, цахилгааны ажлыг бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэн өгснөөр усалгаатай талбайн хэмжээ 2061 га талбайгаар нэмэгджээ. Мөн долоон аймгийн 10 суманд 59 бүлэг хоршоонд 810 ногоочин нэгдсэн ба усалгаатай талбайд тариалалт хийх технологийг эзэмших сургалтуудад хамрагджээ. Энэ онд эдгээр услалтын системийн 785.3 га талбайд 157 ногоочин, хоёр аж ахуйн нэгж тариалалт хийж 1094 тонн төмс, 240.9 тонн хүнсний ногоо, 1280 тонн ногоон тэжээл хураан авчээ.

ӨВӨРХАНГАЙ аймагт 55 хүнсний үйлдвэр, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй, бага хүүтэй, урт хугацаатай зээлд хамрагдаж газар тариалан, мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулахад анхаарчээ. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг “Орда” гурилан бүтээгдэхүүний үйлдвэр тус зээлд хамрагдан тоног төхөөрөмжөө бүрэн шинэчилж, хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлжээ. Мөн аймгийнхаа 11 хүнийг тогтмол ажлын байраар хангаж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Өвөрхангай аймгийн 19 суманд нийлүүлж

Махны экспортын орлогыг 2022 онтой харьцуулахад 285.4 сая ам.доллар болж 71.1 хувиар өсжээ



Долоон
услалтын
системийн
барилга,
цахилгааны
ажлыг
бүрэн
дуусгаснаар
усалгаатай
талбайн
хэмжээ
2061 га
талбайгаар
нэмэгджээ

► байгаа гэдгийг тус үйлдвэрийн захирал Ч.Гантулга хэлж байлаа.

Архангай аймагт 47 хүнсний үйлдвэр, аж ахуйн нэгж тус үндэсний хөдөлгөөний хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, мах, сүү сүүн бүтээгдэхүүн зэргийг дотоодоосоо 100 хувь хангахын зэрэгцээ аймгийн ДНБ-ий хэмжээг 2.6 хувиар өсгөсөн байна. 2023 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” жил болгон зарласны хүрээнд малын эрүүл мэнд, хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах, өндөр ашиг шимтэй малын эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэн төв суурин газрын махны хэрэгцээг хангах зэрэг ажлыг шат дараатай хэрэгжүүлэн ДНБ-ий хэмжээг 2.6 хувиар өсгөжээ. Архангай аймгийн хувьд жилдээ 40.2 тонн мах, 28.7 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангадаг байна.

АРХАНГАЙ аймгийн Цэцэрлэг суманд үйл ажиллагаа явуулдаг “Амин чанар” үйлдвэр бага хүүтэй, хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлд хамрагдан 2024 онд жилд 30 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэрээ Улаанбаатар хотод барьж ашиглалтад оруулжээ.


Мөн Их тамир сумын “Жиферм” эрчимжсэн мал аж ахуйн ферм нь хоёр жилийн өмнө зээлд хамрагдсанаар дэд бүтцээ сайжруулан,

сүү савлагч, ариутгагч зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна.

ӨМНӨГОВЬ аймаг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, ХХААХҮЯ-наас хэрэгжиж байгаа бодлого чиглэлтэй төлөвлөгөөт ажлаа уялдуулж, газар тариалан, мал аж ахуйн салбараа дэмжих “Нутгийн жишиг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Аймгийн удирдлагууд 2023 онд газар тариалан эрхлэгч иргэддээ 400 хүлэмж олгох шийдвэр гаргасан бөгөөд одоогийн байдлаар 100 хүлэмж олгогдож, удахгүй 300 хүлэмж дахин олгох гэж байна.

Улс орон даяар өрнөж буй томоохон төсөл, үндэсний хөдөлгөөнүүд судалгаа, шинжилгээ, эрдэмтэн судлаачдын зөвлөгөө, зөвлөмжийг зайлшгүй тусгах ёстой. Тиймээс Ерөнхийлөгчийн тамгын газраас аймаг, орон нутагт “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний дэргэдэх эрдэмтдийн зөвлөл болон мэргэжлийн холбооны салбар зөвлөлийг 21 аймагт байгуулсан. Ингэснээр орон нутгийн түвшинд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангахад шинжлэх ухаанчаар хандаж, төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн салбарын үйл ажиллагааг илүү зохион байгуулалттай, үр дүнтэй хэрэгжүүлэх юм.


Өөрсдийн газар нутгаас, өөрийн хөдөлмөрөөр эрүүл хүнсээ хангах нь “Хүнсний хувьсгал”-ын бодит үр нөлөө юм. ■



2011-2026

Mongolian Economy

15th Anniversary



ЗӨӨВЧ- ОВОО ТӨСӨЛ

МОНГОЛЫН УУЛ
УУРХАЙН САЛБАРТ
ТЕХНОЛОГИЙН
ДЭВШИЛ АВЧИРНА

Корали Прин

“Бадрах Энержи” ХХК-ийн
ерөнхий захирал

2028 онд уурхайг нээх төлөвлөгөөнд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл бол үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагаа.

Ардчилсан Монгол Улсын түүхэн дэх уул уурхайн хоёр дахь мега төслийг хэрэгжүүлж буй Монгол-Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн ерөнхий захирал Корали Принтай ярилцлаа. Тэрбээр манай улсад томилогдон ажиллахаас өмнө Орано группт 2007 оноос хойш бизнес, стратеги, санхүү хариуцсан удирдах албан тушаалууд хашиж байсан юм.

► **Зөөвч-Овоо ураны ордыг ашиглахаар Монгол Улсын Засгийн газар Франц Улсын “Орано Майнинг” компанитай хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны нэгдүгээр сард байгуулсан. Түүнээс хойш танай хамт олон ямар ажлууд хийж гүйцэтгэв. Төслийн өнөөг хүртэлх үйл ажиллагааг та хэрхэн дүгнэх вэ?**

Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаас хойш бид гурван үндсэн чиглэлд анхаарч байна. Юун түрүүнд бид хөрөнгө оруулалтын гэрээний суурь болон хууль эрхзүйн заалтуудыг ханган ажиллаж байгаа. Та бүхний мэдэж байгаа ачлан уг төсөл маань Монгол Улсын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинэ загвар болж буй. Өөрөөр хэлбэл, “Бадрах Энержи” компанийн Монголын талын 24 хувийн эзэмшлийн таван хувийг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр (АМНАТ) болон ес хүртэлх хувийн өсөн нэмэгдэх АМНАТ-аар орлуулж тооцож авна. Бид шинээр бүрдсэн энэ нөхцөл, зохицуулалтад нийцүүлэн ажиллах зорилгоор тодорхой арга хэмжээ авч байгаа бөгөөд үүний нэг нь “Орано Майнинг Экспаншн” компанид хувьцаа шилжүүлэх үйл ажиллагаа юм.

Бидний анхаарч буй хоёр дахь чиглэл бол байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эцэслэн боловсруулах явдал. Бидний хувьд тун чухал энэхүү ажил дуусах шатандаа орж байна. Ингэснээр бид үйл ажиллагаа явуулж буй аймаг, сум, багийнхаа байгаль орчинд ямар нөлөө үзүүлэхээ бүрэн тодорхойлох юм.

Түүнчлэн бид төслийг эхлүүлэхэд ихээхэн анхаарч байна. Тодруулбал, уурхайн бүтээн байгуулалтыг гурван үндсэн чиглэлээр хийх юм. Эхнийх нь мэдээж дэд бүтэц. Зөөвч-Овоо ордыг бид Дорноговь аймаг дахь хүн ам цөөтэй эзгүй тал газарт хөгжүүлнэ. Тийм учраас уурхайн талбайдаа хүрч очих нөхцөл

бүрдүүлэх үүднээс цахилгааны шугам, зам зэрэг бүхий л суурь дэд бүтэцээ эхнээс нь байгуулж байна.

Хоёрдугаарт, төслийн үйл ажиллагааны амин зүрх гэж болох үйлдвэрийн барилга байгууламжийг барих ёстой. Бид уран боловсруулах болон газар доор уусган олборлох технологид ашиглах уусмалын үйлдвэрээ барина. Энэ хүрээнд уурхайн цоо шинэ технологийг нэвтрүүлж буй нь Монгол Улсын уул уурхайн салбарт томоохон ахиц дэвшил авчирна гэж бодож байна. Олборлолт, үйлдвэрлэлийн нарийн цогц байдлаас шалтгаалж эдгээр байгууламжийн зураг

Монгол Улсад ураны өөр төслүүд хэрэгжих бүрэн боломжтой гэдэгт би итгэдэг

төслийг гаргах, барьж байгуулах ажлыг олон улсын туршлагатай инженерингийн компани барьж, угсарч гүйцэтгэж өгнө.

Манай гурав дахь үндсэн чиглэл нь үйлдвэрлэлийн талбай болон ажилтнуудын байрыг бэлдэхтэй холбоотой. Үндсэн бэлтгэл ажлуудаас гадна ажилтнуудаа тав тухтай, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр байнгын кэмийг барьж буй. Одоогоор эдгээр барилгын тендерийн сонгон шалгаруулалтууд зарлагдсан. Тухайлбал, зам барих, цахилгаан дамжуулах шугамын барилгын ажлыг үндэсний компаниуд гүйцэтгэнэ. Мөн түр кэмп барих ажлыг ч дотоодын компани хийх юм.

Нэмж дурдахад, бид уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээр эрчимтэй ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үндсэн олборлолт 2028 оны сүүлчээр эхлэх ёстой. Бидний хувьд бараг маргааш л гэсэн үг.

Төслийн үйл ажиллагааны өөр нэг

чухал хэсэг нь ажиллах хүч юм. 2025 онд компанийн ажилтнуудын тоо нэг дахин нэмэгдсэн бол 2026 оны эцсээр дахин нэг дахин нэмэгдэх төлөвлөгөөтэй байна.

Хөрөнгө оруулалтын гэрээ нь хоёр талын ашиг сонирхолд нийцэж байгаа гэдгийг та цөөн жишээгээр манай уншигчдад танилцуулж өгнө үү?

Төслийн нийт өгөөжийн дийлэнх буюу 51-ээс доошгүй хувийг Монгол Улс хүртэнэ гэдгийг “Орано Майнинг” баталгаажуулсан. Жишээлбэл, АМНАТ, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 100 хувь Монгол Улсад ногдоно. Ногдол ашгийн 90 хувь нь “Орано Майнинг” компанид, 10 хувь нь Монгол Улсад очно. Хэрэв Монгол Улсын хүртэх өгөөж 51 хувьд хүрээгүй тохиолдолд “Орано Майнинг” өгөөж тэнцүүлэх нэмэлт төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн. Ингэснээр манай төслийн өгөөжийн 50 давсан хувь нь тогтмол Монгол Улсын иргэдэд очих нөхцөл бүрдээд байгаа юм.

Цөмийн эрчим хүчийг ашиглах сонирхол дэлхий даяар эргэн сэргэж байгааг Орано групп анхааралтай ажиглаж буй. Энэ нь эрчим хүчний шилжилт болон цахилгаан хангамжийн эх үүсвэрийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлагаас голлон шалтгаалж байна. Энэ дунд цөмийн эрчим хүч нь олон улсын хувьд эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг хангах хамгийн бодитой бөгөөд стратегийн шийдэл нь болсон. Цаашид ураны эрэлт ихээхэн өсөн нэмэгдэнэ.

Энэхүү нөхцөл байдал нь “Орано Майнинг” компанийн хувьд олборлолтын цар хүрээгээ тэлэх сайхан боломж юм. Бид одоогоор Канад, Казахстанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бидний хувьд Монгол Улс бол үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, шинэ зах зээлд хөл тавих чухал ►

► боломж мөн. Зөвхөн шинэ зах зээл төдийгүй нөөцийн хувьд төрөлжилт бий болгох боломж гэж болно.

Энэ үүднээс авч үзвэл Монгол Улс бол нийлүүлэлтийн эх үүсвэрээ төрөлжүүлэх стратегийн маань тун чухал хамтрагч юм.

Орано групп хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг. Олон улсад танай компанийн хэрэгжүүлж буй томоохон төслүүдээс та танилцуулна уу?

Орано групп цөмийн түлшний мөчлөгийн бүх шатанд ажилладаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ утгаараа Монгол Улс манай уул уурхайн салбарын хувьд нэн чухал түнш. Зөвөч-Овоо төслийн бүтээн байгуулалт удахгүй эхлэх бөгөөд энэ төсөл бидний хувьд стратегийн онцгой ач холбогдолтой. Тийм ч учраас уг төслийг урагшлуулахад шаардлагатай бүхий л дэмжлэгийг бид Парис дахь төвөөсөө авч байгаа.

Манай компани Монгол Улсаас гадна өөр хоёр улсад томоохон төсөл эхлүүлэхэд бэлэн болсон. Эхний төсөл нь Франц дахь уран баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх. Хоёр дахь нь АНУ-д уран баяжуулах шинэ үйлдвэр барих юм. Тус улсын Эрчим хүчний яам Теннесси мужийн Оак Рижэд уг үйлдвэрийг барих онцгой эрхийг 900 сая ам.долларын санхүүжилтийн хамтаар манай компанид олгосон. Уг төслийн нийт төсөвт өртөг нь таван тэрбум орчим ам.доллар юм.

Цөмийн түлшний мөчлөгийн төгсгөл хэсгийг авч үзэх юм бол ашигласан цөмийн түлшний менежментийн талаар ярих ёстой. Орано групп бол ашигласан цөмийн түлшний менежмент, дахин боловсруулах чиглэлд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд ихээхэн туршлага хуримтлуулсан дэлхийн цөөн компанийн нэг. Манай үйлдвэрүүд 30 гаруй жил ажиллаж буй төдийгүй дахин 15-25 жил

ажиллах бүрэн боломжтой. Гэхдээ үүний дараа яах ёстой талаар заавал бодолцох ёстой юм.

Санхүүгийн үзүүлэлтээс гадна манай төсөл Монгол Улсын эдийн засагт өөр олон талаар өгөөжөө өгнө

Энэ бүхнийг нэгтгэж дүгнэвэл 2040–2050 он гэхэд бэлэн болох, шинэ үеийн ашигласан цөмийн түлш боловсруулах үйлдвэрүүд болон түлш үйлдвэрлэх үйлдвэрүүдийг байгуулахад чиглэсэн шинэ загвар, судалгаа-хөгжүүлэлт (R&D), технологийн хэд хэдэн төсөл дээр ажиллаж байна. Энэ нь цөмийн түлшнээс авах үр өгөөжийг дээд зэргээр нэмэгдүүлж, дахин боловсруулах боломжтой түлшинд илүү ойртох боломжийг бидэнд олгоно.


Зөвөч-Овоо төсөл Монгол-Францын харилцаанд ямар нөлөө үзүүлнэ гэж та бодож байна вэ? Мөн уг төсөл Монгол Улсыг чиглэх гадаадын хөрөнгө оруулалт болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниудад эерэг нөлөө үзүүлэх боломжтой юу?

Бид Монгол дахь үйл ажиллагааны

туршлагаас хуваалцахад үргэлж нээлттэй байдаг. Өнөөдөр бидний ажил зарим нэг сорилттой тулгарсан хэдий ч амжилттай урагшилж байгаа нь юун түрүүнд оролцогч талуудын хүлээлтийг сайтар ойлгосон, харилцан итгэлцэл бүхий харилцааг бий болгохоор хүчин чармайлт гаргаж ирсний үр дүн гэж ойлгодог.

Бид энэхүү туршлагаасаа хуваалцаж, Монголыг сонирхож буй гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй мэдээлэл өгөх, туршлага солилцохыг хичээдэг. Манай хөрөнгө оруулалтын загвар тун ойлгомжтой бөгөөд тодорхой. Үйлдвэрлэл эхлэхийн өмнөх хөрөнгө оруулалтыг “Орано Майнинг” болон Орано групп 100 хувь дангаараа хариуцаж буй. Мөн өмнө дурдсанчлан төслийн өгөөжийн дор хаяж 51 хувь Монгол Улсад үлдэх юм.

Санхүүгийн үзүүлэлтээс гадна манай төсөл Монгол Улсын эдийн засагт өөр олон талаар өгөөжөө өгнө. Жишээлбэл, ажлын байр бол монголчуудын төлөө бидний оруулж буй нэг том хувь нэмэр юм. “Бадрах Энержи” компанид нийт 800 гаруй хүн ажиллах бол төслийн туслан гүйцэтгэгч компаниудад мөн ►



Зөвөч-Овоо төслийн түр барилга байгууламжийн угсралтын ажил. Дорноговь аймгийн Улаанбадрах сум

► 800 орчим хүн ажиллана.

Ажлын байр, эдийн засгийн үр ашиг нь улсын хэмжээнд төдийгүй Дорноговь аймагт үлдэнэ. Бид төслөө боловсруулахдаа орон нутгийн хөгжил, эдийн засгийн өгөөж, оролцоог хангах саналуудыг тусгасан, одоо түүнийгээ бодит төлөвлөгөө болгохоор ажиллаж байна.

Нэмж хэлэхэд, бид цаашид хайгуулын ажлуудаа шинээр эхлүүлэх зорилготой байгаа. Зөвч-Овоо бол бидний хувьд эхний алхам. Монгол Улсад ураны өөр төслүүд хэрэгжих бүрэн боломжтой гэдэгт би итгэдэг.

Та манай улсад сүүлийн найман сар ажиллаж, амьдарч байна. Та манай бизнесийн орчны талаар тодорхой ойлголттой болсон гэдэгт итгэлтэй байна. Манай улсын хөрөнгө оруулалтын орчныг хэрхэн үнэлж дүгнэх вэ?

Монголын бизнесийн орчин, соёлоос миний анхаарлыг татсан нэг онцлог бол хурд. Мэдээж аливаа шийдвэр гаргалт нь тодорхой процессын дагуу явдаг, Монголд ч мөн ялгаагүй. Дэлхийн аль ч улсад ийм зүйл байдаг шүү дээ. Харин Монголд шийдвэр нэгэнт гарсан

л бол үйл явдал маш хурдтай өрнөдөг. Энэ нь, үргэлж бэлтгэлтэй байхад хүргэдэг учраас надад үнэхээр таалагддаг Монголын нэг онцлог юм.

Төрийн албан хаагчдыг хүнд сурталтай, шийдвэр гаргахдаа уддаг гэж ихэнх монголчууд үздэг болохоор таны энэ дүгнэлтийг сонсох тун сонирхолтой байна.

Мэдээж удна, хүнд суртал гарна, гэхдээ хүнд сурталгүй улс гэж байхгүй шүү дээ. Жишээлбэл, Францад цөмийн шинэ цахилгаан станц барихын тулд зөвшөөрөл авах, тайлан гаргаж өгөх, цөмийн аюулгүй байдлын агентлаг болон олон нийтийн асуулга, асуултад хариулах гэх мэт олон ажилтай тулгардаг.

Бид нар маш нарийн зохицуулалттай салбарт ажилладаг болохоор ийм түвшний хяналт, шалгалт байхаас ч өөр аргагүй юм. Монгол Улсын хувьд харин шинэ төрлийн ашигт малтмал, уурхайн цоо шинэ технологийг танилцуулж байгаа нь онцлог гэж үзэж болно.

Мэдээж зарим нөхцөлд цаг авах зүйл байдаг ч ийм төрлийн шинэ төслийн талаар шийдвэр гаргагчид зохих ёсны мэдээлэлтэй болох

шаардлага нь үүнд нөлөөлдөг болов уу. Юуг зөвшөөрөх, мөн юуг нь зөвшөөрөхгүй гэдгийг, цаашлаад дэлхийн стандарттай яаж уялдуулах талаар шийдвэр гаргагчид маш сайн ойлголттой болох ёстой юм. Үүнийг ул суурьтай судалгаа, олон улсын стандартын хүрээнд ойлгох ёстой, түүнээс бус баримжаалж ойлголт авах боломжгүй. Тиймээс үүнийг би хэвийн бөгөөд шаардлагатай процесс гэж үзэж байна. Хянамгай хөдөлж, оролцогч талуудад төслийн цар хүрээг бүрэн дүүрэн ойлгуулах нь хамгийн зөв бөгөөд оновчтой шийдэл юм.

Төслийн үйл ажиллагааг 2028 онд эхлүүлэхээр төлөвлөсөн талаар та ярилцлагын эхэнд дурдсан. Хэдий ингэж асуух нь эрт байж болох ч энэхүү зорилгод хүрэх боломжтой гэж та бодож байна уу?

“Бадрах Энержи” компанийн ажилтан бүр энэ зорилгын төлөө ажиллаж байна. Зорилгодоо хүрэхэд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол манай зөвшөөрлүүдийг баталгаажуулах эрх мэдэл бүхий төрийн байгууллагуудтай бүхий л түвшинд нягт, үр дүнтэй хамтран ажиллах явдал юм. Төслийн маань барилгын болон олборлолтын зөвшөөрөл цаг хугацаандаа гарна гэдэгт бид итгэж байна.

Үүнтэй холбоотойгоор бид шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь гаргаж өгөх шаардлагатай. Бид алдаа мадаггүй, үнэн зөв баримт бичгийг цаг хугацаанд нь өргөн мэдүүлэх нь их чухал. Мөн эдгээр баримт бичигтэй хуульд заасны дагуу танилцаж, хянах боломжоор хангахын тулд тэдгээрийг хэзээ танилцуулах талаар холбогдох байгууллагад урьдчилан мэдээлэх нь бидний үүрэг юм. Мэдээж явцын дунд нааш цааш болох тохиолдол гарах ч 2028 онд уурхайг нээх төлөвлөгөөнд маань нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл бол үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагаа гэж бодож байна. ■



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ



Д.Мөнхбат

Орхон аймгийн
ИТХ-ын дарга

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол “малгай” хууль 2003 онд буюу 23 жилийн өмнө батлагдсан бөгөөд нийтдээ 12 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хуульд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдаагүй, зохицуулаагүй зүйлүүд их бий” гэж Орхон аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат ярьж байна.

Орхон аймаг
үргэлж
хүний
хөгжилд
анхаарсаар
ирсэн

Уриа лоозонгийн шинжтэй байсан Бүсчилсэн хөгжил жинхэнэ утгаараа хэрэгжих нөхцөл бүрдсэнд маш их талархалтай байгаа. Орон нутгийнхаа зарим асуудлыг шийдвэрлэхийн тулд хөрш аймгуудтай хамтран ажиллах шаардлага бий. Аймгийн ИТХ 2020-2024 онд орон нутгийнхаа хөгжлийн төлөө, тулгамдаж буй асуудлуудаа шийдвэрлэхийн тулд Орхон, Булган аймгийн ИТХ-уудтай ижил шийдвэр гаргасан. Тодруулбал, 2024 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэр, технологийн парк байгуулах, хаягдлын шинэ сан байгуулах зорилгоор газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг бид хамтран

дэмжсэн тогтоол баталж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Энэ бол бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал орон нутагт хэрэгжих анхны сайн жишээ болсон гэж боддог.

Хойд бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс” болно гэж тодорхойлсон. Манай бүс өөрөө уул уурхай, аялал жуулчлалын суурь өгөгдлүүддээ тулгуурлан хөгжинө гэж үзэл баримтлалаа тодорхойлсон. Үүнээс хэд хэдэн зорилтыг Орхон аймагт тухайлан хэрэгжүүлнэ. Тодруулбал, манай аймагт нэгдүгээрт, зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, хоёрдугаарт, бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулна. Гуравдугаарт, бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна. Дөрөвдүгээрт, тээвэр логистикийн зангилаа төв байгуулахаар тусгасан.

Бид өнгөрсөн оны зургаадугаар сарын 26-нд хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит бус тавдугаар хуралдаанаар Орхон аймагт төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг баталсан. Төслүүдийн эхэнд Хойд бүсийн тээвэр логистикийн төвийг хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахаар тусгаад байна. Мөн Хойд бүсийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ-ийг боловсруулах хүсэлтээ Эдийн засаг, хөгжлийн яаманд өгсөн. Орхон аймгийн тухайд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд өөрсдөөс шалтгаалах зүйлсээ хийж байна.

Бүсчилсэн хөгжлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчны тухайд хэд хэдэн хууль, тогтоомж, дүрэм, журам бий. 2003 онд батлагдсан Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай ▶

► хууль, Монгол Улсын Их хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2025 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан Бүсийн хэлэлцээр байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 2025 оны 15 дугаар тогтоолоор баталсан Бүсийн зөвлөлийн ажиллах журам байна. Эрх зүйн баримт бичиг хангалттай юм шиг боловч хэрэгжилтийн шатанд дутагдалтай зүйлс их байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг салбарын олон хууль тогтоомжид бүс гэсэн ойлголт огт байхгүй.

Нэг жишээ хэлэхэд, бид ундны усны эх үүсвэрийг хамгаалах зориулалтаар хөрш аймаг, сумынхаа нутаг дэвсгэрт ямар ч ажил хийх боломж хуулиараа байхгүй. Угтаа бол тэр усыг ууж, хэрэглэж байгаа нь манай аймгийн иргэд шүү дээ. Энэ мэтчилэн олон асуудал бий. Дээрээс нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол “малгай” хууль нь 2003 онд буюу 23 жилийн өмнө батлагдсан бөгөөд нийтдээ 12 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хуульд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдаагүй, зохицуулаагүй орхигдсон зүйлс их бий.

Тиймээс эн тэргүүнд Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчлэх нь зүйтэй. Мөн бодлогын түвшинд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг оролцоог хуульд тодорхой болгож, нэмэгдүүлэх шаардлага бий. Бүсийн зөвлөл болон Салбар зөвлөлийн ажиллах журмыг батлах хэрэгтэй байна. Учир нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн бүсийн бодлогыг ямар субъект батлах вэ, бүсийн хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бүсийн төсвийн асуудлыг яаж шийдэх вэ, ямар субъект батлах вэ, Бүсийн батлагдсан бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг ямар субъект хяналт тавих вэ, бүсийн хэмжээнд газрын харилцаа, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх зэрэг асуудлаар хамтын шийдвэр (захиргааны акт)-ийг ямар субъект, хэрхэн гаргах вэ гэх мэт асуудал тодорхойгүй байна.

Аймгийн ИТХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг, оролцоог хуульд тодорхой заагаагүй. Зөвхөн Бүсийн зөвлөлд нутгийн өөрөө удирдах ёсны төлөөлөл байж болно гэсэн заалттай. Тэр нь байхгүй ч байж болно гэсэн үг шүү дээ. Гэхдээ бид Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан зорилтуудаас орон нутгийн түвшинд шийдвэрлэх, хэрэгжүүлэх боломжтой зорилтуудаа Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, аймгийн ИТХ-ын ээлжит бус гуравдугаар хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Бид ИТХ-аараа 2025-2028 онд хэрэгжих аймгийн Засаг даргын “Эрдэнэт хүний хөгжил” үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Үйл ажиллагааны хөтөлбөр, бүсийн хөгжилд Орхон аймаг яаж оролцох, мөн “Эрдэнэт шинэ илгээлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхой тусган баталлаа. Орхон аймаг үргэлжид хүний хөгжилд анхаарсаар ирсэн. Ялангуяа эмч, багш нарынхаа ур чадварыг үнэлж, гадаад дотоодод туршлага судлуулах зэрэг олон арга хэмжээг сүүлийн 10 жилийн турш хэрэгжүүлж байна.

Орхон аймаг, Эрдэнэт хот бол үйлдвэр дагасан хот. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Ачит ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс эрдэнэ” ХК зэрэг томоохон уул уурхайн үйлдвэртэй. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 85 орчим хувийг уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбар бий болгодог. Бид 2023-2024 онд 301.7 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2025 онд 145.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, эргээд улсын төсвөөс 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийнэ. Энэ онд улсын төсвийн шинэ хөрөнгө оруулалтын ажил байхгүй. 2018-2024 онд эхэлсэн ажлууд үргэлжилнэ.

Орхон аймгийн нэг хүнд ногдох ДНБ 11 мянган ам долларт хүрсэн. Монгол Улсын Засгийн газраас нэг хүнд ногдох ДНБ-ийг 10 мянган ам.долларт хүргэх зорилт тавьж буй. Гэтэл манай аймаг хэдийн 10 мянган ам долларт хүрчихсэн ч үр өгөөж нь иргэддээ ирэхгүй байна. Түрүүн хэлсэнчлэн, бид 145.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлчихээд эргээд 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг л улсын төсвөөр гүйцэтгэж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-ын дарга болсноосоо хойш уламжилж байна. ■

Бид 145 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлээд эргээд 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг л улсын төсвөөр гүйцэтгэж байна

ШИНЭ ТЕХНОЛОГИ НУТАГШУУЛЖ, ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ НЭВТРҮҮЛСЭН БҮС БОЛНО



Д.Пүрэвдорж

Хөвсгөл аймгийн
ИТХ-ын дарга

“Бүсчилсэн хөгжил бол малчдад маш хэрэгтэй бодлого. Үүнийг малчид маань ойлгож эхэлсэн” гэж Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Д.Пүрэвдорж ярьж байна.

Аялал
жуулчлал
бол манай
аймгийн
нэрийн
хуудас

Бүсчилсэн хөгжил бол Монгол Улсын хувьд цоо шинэ зүйл биш юм. Социализмын 70 жилд ч мал аж ахуйн үндсэн салбараараа бүсчлэн хөгжиж ирсэн түүхтэй. Хөвсгөл аймгийн хувьд зүүн хэсгээр хонь, баруун талаараа үхэр сүргийг түлхүү үржүүлэх бодлоготой байв. Өвөлжилтийн отрын нутаг, хадлан тэжээл авдаг бүс нутаг гэх мэтчилэн зааж, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайн зохион байгуулж байсан.

Харин зах зээлийн системд шилжсэнээр ард иргэд төрсөн нутаг усандаа дур дураараа суурьших болж, бүс нутгийн төлөвлөлт алдагдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, хадлангийн бүсийн асуудал ярихаар бид хаана амьдрах нь миний эрх гэсэн байдал руу орсон. Бүсчлэн хөгжих үзэл баримтлалын хүрээнд өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн бодлого, ажлуудын сайн туршлагуудыг өвлөн авч, үлгэрлэн үргэлжлүүлж хөгжих нь чухал юм.

Хөвсгөл аймгийн ихэнх айл өрх мал аж ахуй эрхэлж амьдардаг. Манай аймаг 2024 оны байдлаар 5.2 сая толгой мал тоолуулж, 21

аймгаа тэргүүлж байна. 2019-2020 оны өвөл хүнд болж, мал нэлээд хорогдсон бол 2023-2024 оны өвөл аймгийн хэмжээнд долоон сум зудын байдалтай байв. Галт суманд л гэхэд 90 мянган мал хорогдсон. Мал нь цаг уурын эрсдэлтэй тулж, хорогдохоор малчдын амьдрал хүндэрдэг. Тиймээс бүсчилсэн хөгжлийн хүрээнд хадлан тэжээлээр хэрхэн хангах, бэлчээр ашиглалтыг хэрхэн сайжруулах, малын тэжээлийг хэрхэн сайн бэлтгэх зэрэг асуудлын хүрээнд бид Малчдын зөвлөгөөн хийсэн.

Малчид хорших байдлаар ажиллаж, малын өвс тэжээлийг сайн бэлтгэж авснаар зудыг амжилттай даван туулна, байгалийн давагдашгүй хүчин зүйлийг эрсдэл багатай давна. Бүсчилсэн хөгжил бол малчдад маш хэрэгтэй бодлого. Үүнийг малчид маань ч сайн ойлгож эхэлсэн. Энэ чиглэлийн санал гарсан учраас бид аймгийн хүрээнд жижиг оврын 50 морины хүчин чадалтай хадлан хадаж, газар хагалдаг, зам харгуй засдаг 20 тракторыг малчдадаа бүсчилсэн байдлаар хуваарилж өгөхөөр төлөвлөж байна.

Хөвсгөл аймаг 23 сум, нэг тосгонтой. Би аймгийнхаа 22 суманд очиж, ажил байдалтай нь танилцан ард иргэдтэйгээ уулзсан. Цагаан-Үүр сумын санаачилгаар Эрдэнэбулган, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумдад бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөнийг хийж, зүүн хойд бүсийнхэн бид ямар давуу байдлаар хөгжих боломжтой талаар ярилцсан.

Таталцлын төвүүдийг хэрхэн хөгжүүлэх вэ? Эхний удаад дэд бүтцийн асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай байна. Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болчихвол махны үйлдвэр барья гэсэн саналтай байна. Бүх үзүүлэлтээр тэргүүлж буй сумдад үйлдвэрлэл хөгжих боломжийг бүрдүүлж өгвөл ойр орчмын сумын малчид малаа аймгийн төв рүү туухгүйгээр орон нутгийн төвдөө очоод өгчихдөг болно. Энэ мэтчилэн аймгийнхаа сумдыг бүсчлэн хөгжүүлж, малчдын аж амьдралыг сайжруулахад чиглэсэн олон ажил хийж болохоор байна. ▶

► Гадаад, дотоодын жуулчдын урсгалыг хамтран татахад анхаарна

Аялал жуулчлал бол манай аймгийн нэрийн хуудас. Бид аймгийнхаа аялал жуулчлалын салбарыг дата мэдээлэлжүүлэх ажлыг сайн хийх ёстой. Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын ихэнх нь говь руу явдаг. Хөвсгөл рүү ирэх нь тун бага байна. Харин дотоодын маш их жуулчин Хөвсгөл нуураа зорьж ирдэг. Хөвсгөл аймгийг зорих гадаад, дотоодын жуулчдын урсгалыг Орхон, Булган аймгууд хэрхэн татаж хамтран ажиллах вэ гэдэгт анхаарах ёстой. Энэ нь өөрөө бүсийн бодлогоор тодорхойлогдоно. Тухайлбал, гурван аймгийн хамтарсан аялал жуулчлалын тусгайлсан бүтээгдэхүүн гаргах боломжтой. Хөвсгөл аймгийг зорих жуулчид Орхон, Булганаар дайрч, Орхон аймагт зууны манлай “Эрдэнэт” үйлдвэрийг үзэх аяллыг жуулчдын хөтөлбөрт оруулж болно. Дараа нь айрагны өлгий нутаг Булган аймгаар дайрч монгол ахуй, үзэсгэлэнт байгаль, уул усыг үзэж саатаад Хөвсгөл рүү явах аялал жуулчлалын маршрут гаргах зэргээр бүсийн хэмжээний төлөвлөлт хийх зайлшгүй шаардлага бий.

Хөвсгөл аймаг аялал жуулчлалын салбартаа жилээс жилд ахиц гаргахын төлөө ажиллаж байна. Аялал жуулчлалын салбарт 40 жилийн туршлагатай Япон мэргэжилтнийг аймгийн Политехникийн коллеждоо хоёр жил ажиллах гэрээтэй авчирсан. Энэ эрдэмтнээр Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг хийлгэж байгаа юм. Юун түрүүнд, аймгийнхаа бүх мэдээллээр дата бааз бий болгохоор ажиллаж байна.

Хойд бүсийн аймаг бүрд тулгамдсан асуудал бий. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсүүдийн онцлогоор хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Бодит байдалд төр засгаас шийдэх асуудлууд их байна. Тухайлбал, “Цахим аймаг” бодлогын хүрээнд бүсийн аймгуудын цахимжилтад анхаарах, хамтын төлөвлөлт, үр дүнг хянах, дүгнэх зэргээр бүсчлэн хөгжих аргагүй, тогтолцоог нэвтрүүлэх шаардлага бий.

ОХУ 2025-2026 онд Ханх боомтыг олон улсын боомт болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус боомтыг Монгол Улсын Засгийн газар хойд хөрштэй хиллэх Алтанбулагийн дараах хоёр дахь боомт болно гэж үзэж, түүнд нь тохирсон дэд бүтцийг бий болгох үүднээс Хатгалаас Ханх руу авто зам барихаар төлөвлөсөн. Энэ нь манай аймаг төдийгүй Хойд бүсийн хөгжилд эергээр нөлөөлж, аялал жуулчлал, худалдаа

үйлчилгээ нэмэгдэх, иргэдийн орлого өсөх, хөгжлийн нэг том гарц болно гэж үзэж байна.

Хойд бүсийн аймгуудад тулгамдсан ямар асуудал байна, түүнийгээ хоорондоо ярилцаж, туршлага хуваалцах ёстой. Тухайлбал, Эрдэнэтийн эрүүл мэндийн салбарынхан Хөвсгөл аймгийн эмнэлгийн ажилтнуудтай туршлага солилцож, сургалт хийж болж байна. Хөвсгөлчүүд Улаанбаатар явах бус Орхон аймгийн эмнэлгээр үйлчлүүлээд сэтгэл хангалуун нутагтаа ирдэг байх нь л бүсчилсэн хөгжлийн бодлого юм шүү дээ. Бүсийнхээ бүх сургуулийг цахимжуулахад “Эрдэнэт” үйлдвэр хөрөнгө оруулалт хийх зэрэг санаачилгууд байна.

Мөн шинэ технологи нутагшуулж, хиймэл оюун ухааныг нэвтрүүлсэн бүс болохын төлөө нэгдэж ажиллан, хамтраад дата бааз бий болгох зорилго бий. ИТХ бол иргэдээ төлөөлж буй төлөөллийн байгууллага. Хурлаас гарч буй шийдвэр бүхэн иргэдийн санал, бодлыг илэрхийлэх ёстой. Бид аймгийн Засаг даргын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Ард иргэдээ аятай тухтай амьдрах боломжоор хангах, хүн төвтэй хөтөлбөр болсон гэж үзэж байна. Тухайлбал, “Ногоон Мөрөн”, “Өнгөлөг Мөрөн” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээ. Мөн аймгийн ИТХ-ыг цахимжуулах ажлыг хийж байна. Аймаг, сумаа төлөөлсөн ИТХ-ын гишүүд товлосон хурал бүрд ирж оролцоход хүндрэлтэй байдаг. Түлш шатахууны гээд үйл ажиллагааны зардал төлөөлөгчдөд байдаггүй. Тиймээс ИТХ-ын үйл ажиллагааг цахимжуулах нь чухал ач холбогдолтой.

Аймгийн ИТХ-ын сүүлийн хурлыг 90.4 хувийн ирцтэй зохион байгуулсан нь технологийн үр дүн гэж харж байгаа. Одоо аймгууд мэдээлэл технологийг ашиглах цаг нь ирсэн. Мөн бид иргэдийн саналыг сонсох зорилгоор D-Parliament-ийн жижигрүүлсэн хувилбарыг нэвтрүүлээ. Энэ нь аймаг, орон нутгийнхаа хөгжлийг яаж харж байна, юу хийх саналтай байна, юунд бухимдаж байна зэргээр иргэдийнхээ саналыг сонсох зорилготой платформ юм. ИТХ-ын үйл ажиллагаа, санхүүгийн болон нийтийн мэдээллийн ил тод байдлын үзүүлэлтээр эхний улиралд манай аймгийн ИТХ 21 аймгаас эхний аравт орсон. Аймгуудаас Хөвсгөл аймгийн ИТХ тэргүүн байрт орсон. Бид одоо сумдын ИТХ-ыг цахимжуулахаар төлөвлөн ажиллаж байна. ■

Хойд бүсийн аймгуудад тулгамдсан ямар асуудал байна, түүнийгээ хоорондоо ярилцаж, туршлага хуваалцах ёстой



С.Цэрэндэмбэрэл

“Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” НҮТББ-ын Тэргүүн

ХИЛИЙН ЧАНАДАД БУЙ ИРГЭДЭД ХАНДСАН ТӨРИЙН БОДЛОГО ХЭРЭГТЭЙ БАЙНА

“Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” НҮТББ-ын Тэргүүн С.Цэрэндэмбэрэлтэй ярилцлаа. Тус байгууллага Дэлхийн монголчуудын анхдугаар наадмыг өнгөрсөн зун Бельги улсад, Хилийн чанадад сурч буй оюутан, залуучуудын чуулга уулзалтыг БНТУ-ын Истанбул хотноо 2025 оны арваннэгдүгээр сард зохион байгуулсан билээ.

Хилийн чанад дахь монголчууд жилд 2 тэрбум ам.долларыг эх орондоо оруулдаг

Дэлхийн улс орнуудад сурч буй монгол залуусын цар тахлаас хойших хамгийн том цугларалт Турк улсын Истанбул хотод болсон. Уг уулзалтын үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ?

Хилийн чанадад 300 мянга орчим монгол иргэн ажиллаж, амьдардаг. Үүний 70-80 мянга нь оюутнууд гэж бид тооцоолж байгаа. Ер нь хилийн чанадад буй монгол иргэдийн талаас илүү нь 45-аас доош насныхан буюу залуучууд. Иймээс

“Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” (ХЧМЗ) НҮТББ-ын анхаарлын төвд оюутан залуучууд байдаг. Манай зөвлөлийн үйл ажиллагааны бүтцэд дөрвөн хороо байдгийн нэг нь Оюутан залуучуудын хороо юм. Хорооны гол зорилго нь хилийн чанадад сурч буй оюутан, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, холбоо харилцаа бий болгох, танилцуулах, урам өгөх, туршлага мэдээлэл солилцох, үйл ажиллагааг төрийн бодлоготой уялдуулахад чиглэдэг. ▶

► Үүний нэг хэсэг нь Хилийн чанад дахь монгол оюутан залуучуудын чуулга уулзалт юм. Анхны чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо Төрийн ордонд 550 гаруй оюутан залуусын оролцоотой зохион байгуулсан бол түүнээс хойш ОХУ, Япон, Хятад, Өмнөд Солонгос, хамгийн сүүлд 2019 онд Унгарт зохион байгуулсан. Зургаадугаар чуулга уулзалтыг БНТУ-д хийхээр төлөвлөсөн ч Ковид цар тахал гарснаар хойшлогоод зургаан жилийн дараа Туркийн Истанбул хотноо боллоо. Энэхүү уулзалтад 24 улсаас 250 гаруй монгол оюутан, залуус ирж оролцсон.

Энэ удаад зөвхөн оюутнууд төдийгүй хилийн чанадад ажиллаж амьдарч буй залуусыг оролцуулснаараа онцлог боллоо. Оюутнууд маань өргөнөөр оролцох боломжтой гэж үзсэн учраас Турк улсыг сонгосон юм. Визийн хязгаарлалтгүйгээс гадна газарзүйн байршил, тээвэр, логистикийн хувьд Европ, Азийг холбосон улс. Түүнчлэн ХЧМЗ-ийн томоохон баг энд ажилладаг тул Истанбулыг сонгосон гэж болно.

Тус чуулга уулзалтад ирсэн оюутнуудын 70 гаруй хувь нь техник технологи, инженер зэрэг нарийн мэргэжлээр сурч буй оюутнууд байсан нь бас нэгэн онцлог байлаа. Бидний гол зорилго бол оюутан залуусаа уулзаж танилцуулах, холбоо харилцаа бий болгох, мэдлэг туршлага хуваалцах, урам өгөх, тэднийг оролцоог нийгмийн хөгжилд татан оролцуулах юм. Тэрхүү зорилгоо энэ удаад бүрэн биелүүлсэн гэж бид үзэж байгаа.

Чуулга уулзалтын үндсэн илтгэлүүдийн агуулга дээр сайн ажиллажээ. Монголын ирээдүй болсон залууст эдгээр илтгэлээр дамжуулан юу өгөх вэ гэдэгт анхаарч сэдэв, илтгэгчдээ сонгосон байна. Илтгэлүүдээс эх орон, үнэт зүйлс, ирээдүйн хөгжил, залуусын хүч гэсэн агуулгууд үнэртэж байлаа.

Чуулганы үндсэн сэдэв нь “Дэлхийд хүрэх монгол оюун”. Гадаадад сурч буй оюутан залуусыг 3-4 бүлэгт хувааж болно. Нэгд, Монголд төгсөөд гадаадад суралцаж буй том бүлэг орно. Хоёрт, хувиараа, эсвэл төрийн сан, тухайлбал, Ерөнхийлөгчийн илгээлтээр сурч буй бүлэг. Гуравдугаарт, аав ээж нь 20,30 жилийн өмнө тухайн улс оронд очиж ажиллаж амьдарсан бүлэг байна. Дөрөвдүгээрт, эх орондоо сургуулиа төгсөөд гаднын улс оронд бакалавр, магистраа хамгаалан тухайн улсад мэргэжлээрээ ажиллаж буй хэсэг байна. Энэ бүлэг залуусын оролцоог уг чуулга уулзалтаар

хангаж өгснөөрөө Истанбулын арга хэмжээ их ач холбогдолтой.

Дэлхийн олон оронд сурч, ажиллаж буй монголчууд хамгийн түрүүнд ази царай зүсээрээ ялгарна. Дараа нь үндэсний хэл соёл, өв уламжлалаар ялгарч ондоошно. Энэ утгаар залууст монгол хүн байхын утга учир, монгол хүн болж төрсний онцлог давуу тал, Монгол Улсынхаа түүх соёл, уламжлал, үндэсний онцлогийн талаар ойлголт мэдээлэл өгөхийг хүссэн. Тухайлбал, судлаач, доктор Ё.Отгонбаяр гуай “Монгол хүн байхын утга учир” илтгэл тавилаа. “Монгол адууны диваажин” хөтөлбөрийг санаачлагч, монгол адууны чиглэлээр томоохон ажлууд хийж байгаа Б.Наранбадрах монгол адуу, монгол соёл өв соёл болон “Хүний энэрэнгүй сэтгэл” сэдвийн хүрээнд ярилаа.

Нийт зургаан илтгэгч бид урьсан. Эхний илтгэлүүдээр монгол хүн байхын утга учир, өв соёл, ондоошлын талаар судалгаа баримттай ярьж залуусын урам зоригийг сэргээсэн. Хоёр дахь хэсэг нь Их Британийн Лондон Саут Банк их сургуулийн бизнесийн сургуулийн ахлах багш, МВА хөтөлбөрийн захирал Х.Саранзаяа доктор “Өөрсдийн үнэт зүйлс, онцлогт тулгуурлан дэлхийн иргэд болох нь” илтгэлээ уншлаа. “Даяаршсан нүүдэлчин” шинэ үеийн монгол залуус дэлхийд ямар үнэт зүйл, хувь нэмэр авчрах болон монгол онцлогтой маркетингаар дэлхийн зах зээлд гарах боломжийн тухай илтгэл байв.

Монголын оюун ухааны академийн ерөнхийлөгч, гавьяат багш Х.Хатанбаатарын шинэ орчинд амжилттай суралцах, өөрийн чадавхыг хөгжүүлэх, суралцах ур чадварын цогц ойлголт бүхий “Хурдтай суралцах чадвар” илтгэл оюутан залуучуудын сонирхлыг ихэд татлаа. “Mongolian Economy” сэтгүүлийн Ерөнхий Эрхлэгч Д.Бэхбаяр “Монгол залуусын ирээдүйн боломж ба сорилт” илтгэлээрээ Монгол Улсын ойрын болон ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал, бодлогын талаар товч танилцуулж, түүнд залуусын боломж, оролцоо хэр байх, шинэ үеийн залуусыг хөгжлийн ямар бодлоготой улс орон хүлээж байгаа талаар мэдээлэл өглөө.

ХЧМЗ-ийн дэд тэргүүн асан, SKS LLC-Deed motors, Japanshop.mn үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал А.Долгион “Гэртээ харих зам-Гэрэл ба давс болохын үнэ цэн” илтгэлээр дамжуулан гадаадад сурч байх хугацаандаа бусдын төлөө сайн дурын ажил хийхийн үнэ цэн, гэртээ харих

Гадаадад сурч буй оюутнуудыг төр болон төрийн бус, бизнесийн байгуул-лагуудад дадлага хийх боломжоор хангана

Нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар төлөх нь гадаадад буй иргэдэд маш чухал

▶ замаа тодорхойлон эх орондоо буцаж ирэх шийдвэрийн хүч, Монголдоо хэрхэн очих, эргэж очоод ажиллаж амьдрахад тулгардаг асуудлууд, гарц шийдлийн талаар өөрийн жишээнд тулгуурлан ярьсан нь залуусын урам зоригийг сэргээж өглөө.

Мөн чуулга уулзалтын нэг гол зорилго оюутан залуусын улс орныхоо хөгжилд оролцох оролцоог нэмэгдүүлэх үүднээс NextGen төслийн уралдааныг зохион байгуулсан. Залууст урам өгөх, тэдний санал санаачилгыг бодитой болгох, Монгол орны хөгжилд залуусын хувь нэмрийг татан оруулах үүднээс NextGen төслийн уралдааныг зарласан юм. Эхний шатанд 19 төсөл ирснээс есөн төслийг шалгаруулсан. Энэхүү есөн төслийн оролцогч оюутнуудад чуулга уулзалтын үеэр төслөө биечлэн танилцуулах боломж олгосноор эхний гурван байрын төслийг шалгаруулж, мөнгөн шагналаар шагнасан.

Оюутнууд маань улс оронд тулгамдаж буй асуудлуудыг сурч буй мэргэжил чиглэлээрээ хэрхэн шийдэж болох талаар төслийн санаагаа бичсэн юм. Тухайлбал, нийслэлийн утааны асуудлыг шийдэх, боловсролын сургалт хөгжлийн арга барилыг технологийн аргаар шийдэх, хөдөөний малчдад үйлчилгээ үзүүлэх дроны төсөл, ногоон байгальд ээлтэй технологийн төслүүд байлаа. Шалгарсан төслүүдийг хэрэгжүүлэхэд ХЧМЗ, Оюутан залуусын хороо дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Бид Оюутан залуусын чуулганыг зохион байгуулахаас гадна дадлагажигч оюутан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлагатай. Гадаадад сурч буй оюутнуудыг төр болон төрийн бус, бизнесийн байгууллагуудад дадлага хийх боломжоор хангадаг энэхүү хөтөлбөрийг эргэн сэргээхээр бид ярилцаж байна. Зуны амралтаараа дадлага хийсний дараа оюутнуудын 20-30 хувь нь тухайн байгууллагадаа ажилд орсон гэсэн үзүүлэлт бий. Мөн бид ажиллах боловсон хүчнийг холбох зорилготой Хөдөлмөрийн яармагийг зохион байгуулж ирсэн бөгөөд энэ ажлыг үргэлжлүүлэхээр судалж байна.

Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлийн 2025 онд хийсэн нэг том ажил бол Дэлхийн монголчуудын наадмыг зохион байгуулсан явдал гэж дүгнэж болох уу?

Дэлхийн монголчуудын наадам зохион байгуулахаар 2021 оноос ярьж хэлэлцээд 2025 оны зун хийлээ. Хилийн чанад дахь монголчууд маань дэлхийн 30 гаруй улсын 50 гаруй газарт

Үндэсний баяр наадмаа тэмдэглэдэг. Харин эдгээр наадмыг нэгтгэж, Монгол бахархлыг сэргээх, монгол хүүхдүүдийн хэл, соёл уламжлалыг нэгтгэх зорилго бодлоготой арга хэмжээг хийхээр 2021 оноос төлөвлөсөн. Энэ санал санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хүлээн авч дэмжлэг үзүүлсэн боловч цар тахал таарснаас болж хойшилсон. Ингээд 2025 оны зургаадугаар сард Дэлхийн монголчуудын анхдугаар наадмыг Бельги улсын нийслэл Брюссель хотод хийсэн. Уг наадмыг Монгол Улсын төр засгийн бодлого болох "Үндэсний наадам" брэндингтэй уялдуулж монгол уламжлалт өв соёлоо дэлхий дахинаа сурталчлах хүрээнд хийлээ.

Брюссель хот нь Европын холбооны нийслэл гэгддэг, Монгол Улсын гадаад бодлогын хувьд чухал ач холбогдолтой гэдэг утгаар, мөн монголчуудынхаа ирж очих боломж, төвлөрлийг харж сонгосон. Европт нийтдээ 100 мянга орчим монголчууд байдаг гэж үзвэл таван хувь буюу 5000 орчим монгол биечлэн ирж наадамдаа оролцлоо. Монголчууд Брюсселийн хамгийн том цэнгэлдэх хүрээлэнд хоёр өдрийн турш баярлаж наадсан. Яг л эх орондоо наадамлаж буй мэт сэтгэгдэл төрсөн. Зүлэг ногоон дэвжээнээ 128 бөх барилдаж, 50 гаруй харваач нум сумаа харваж, 400 орчим шагайн харваач оролцсон. Бид хоолны 20, бүтээгдэхүүн үйлчилгээний 20 гаруй асар барьсан. Түүнчлэн консулын үйлчилгээ, сайн дурын нийгмийн үйлчилгээг үзүүлсэн нь иргэдийн талархлыг хүлээлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор болсон тул төрийн зүгээс өндөр ач холбогдол өгч дэмжсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, ЕТГ, Засгийн газар, Гадаад хэргийн яам, Монголын үндэсний спортын хорооны удирдлагуудад энэ ташрамд баярлаж талархсанаа илэрхийлэе.

Монголчуудаар зогсохгүй тухайн улсын иргэдийн сонирхлыг ч татсан сайхан наадам болсон байх. МҮОНТВ-ээр үзээд тийм сэтгэгдэл төрж байлаа.

Тийм ээ. МҮОНТВ-ээр дамжуулсан. Гадаадын 15 мянга орчим иргэн манай наадмыг үзэж сонирхсон. Үйл ажиллагааны зохион байгуулалтыг ХЧМЗ, төрийн байгууллагуудаас гадна Европт буй дипломат төлөөлөгчийн бүх газрууд, тухайн улсад буй ТББ-ууд, урлаг, спортынхон дэмжиж, бид олон сарын турш хамтран ажилласны үр дүнд наадам маань маш сайхан болсон. ▶



► Хилийн чанад, Европын улс орнуудад буй монгол иргэд тэр бүр эх орондоо очиж наадаж чаддаггүй. Тэгвэл яг л эх орондоо очсон мэт сайхан наадам боллоо гэцгээж байв. Дэлхийн монголчуудын наадам дараа жил өөр тивд болно. Одоохондоо байршлаа сонгоогүй байна. Бэлтгэл ажилдаа бид хэдийнээ орсон.

Нийгмийн даатгалын асуудал гадаад дахь монголчуудын хувьд бэрхшээл байсаар ирсэн. Энэ асуудал хэрхэн шийдэгдэж байна вэ?

ХЧМЗ 2014 онд үүсгэн байгуулагдсан. Тухайн үеийн Гадаад харилцааны сайд Л.Болдын дэмжлэгтэйгээр хилийн чанадад буй төрийн бус байгууллагууд уулзаж, нэг тогтолцоогоор ажиллах нэгдсэн байгууллагатай болох хэрэгтэй гэж үзсэнээр ХЧМЗ байгуулагдсан. Байгуулагдсан цагаасаа л иргэдийн эрх, нийгмийн тулгамдсан асуудлуудыг анхаарлын төвдөө байнга байлгаж ирлээ. Тухайлбал, гадаадад буй ээжүүд Алдарт эхийн одонгоо авч чаддаггүй байсныг 2017 онд шийдүүлсэн. Гадаад дахь монголчууд тухайн орондоо нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бөгөөд тэтгэврийн насанд ирж, эх орондоо очихоор тухайн улсад төлсөн шимтгэлээ авч чаддаггүй асуудалтай нүүр тулдаг.

Нийгмийн хамгааллын асуудлууд нь тухайн улс орны хуулийн зохицуулалтаас хамаардаг. Тухайлбал, Герман тэтгэврийн

санд хуримтлагдсан мөнгийг нь өгдөг бол Польш өгдөггүй. Гэхдээ гарц гаргалгаа бий. Нийгмийн хамгааллын талаарх олон улсын гэрээ хэлэлцээр гэсэн үндсэн баримт бичигт жишээлбэл, иргэний тухайн улсад төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг хүлээн зөвшөөрөөд эх орондоо очиход нь хоёр улсын нийгмийн даатгалын салбарууд нь мэдээллээ харилцан солилцсоноор тэтгэвэр авах боломж үүсдэг тухай заасан. Олон улсын энэхүү эрх зүйн актаар хэлцэл хийдэг юм байна. Монгол Улс БНСУ, БНТУ, Унгар, Чех, Казахстан, Польш зэрэг орнуудтай ийм хэлцэл хийсэн. Дараагийн ээлжинд Австрали, Швед, Австри, АНУ яригдаж байна. Мэдээж Засгийн газрын түвшинд гэрээ, хэлэлцээр байгуулагдсаны дараа тухайн улсын парламентаар соёрхон баталснаар гэрээ хүчин төгөлдөр болдог. 2025 оны УИХ-ын хаврын чуулганаар Казахстан улстай хийсэн гэрээг соёрхон батлах асуудлыг хэлэлцээд дэмжлэг аваагүй. Засгийн газар, салбарын яам энэ асуудлыг УИХ-д дахин оруулах байх гэж найдаж байна. Энэ бол эхний боломжит хувилбар юм.

Хоёр дахь хувилбар бол нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар төлөх. Энэ нь гадаадад буй иргэдэд маш чухал асуудал. Зөвхөн тэтгэврийн насныхан бус насанд хүрсэн хүн бүрд хамаатай. Сурах, ажиллах хугацаандаа сайн дурын даатгалд хамрагдаад явбал Монголдоо очиход маш хэрэгтэй. Эмнэлгийн

Хоёр улсын нийгмийн даатгалын салбарууд нь мэдээллээ харилцан солилц-соноор тэтгэвэр авах боломж үүсдэг тухай заасан



Нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар төлөх нь гадаадад буй иргэдэд маш чухал

► үйлчилгээ авах, тэтгэвэр авах нөхцөл нь үүснэ. Сайн дурын даатгалд хамрагдсанаар гадаадад байхдаа хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд нөхөн олговор авах боломж ч нээгдсэн. БНСУ-д буй монгол иргэд төрийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу сайн дурын даатгал төлдөг учраас жилдээ дунджаар дөрвөн тэрбум төгрөгийн шимтгэл бүрдүүлдэг гэсэн мэдээлэл бий. Тэгэхээр бусад оронд буй монгол иргэд ч шимтгэлээ төлөөд явбал энэхүү мөнгөний хэмжээ нэмэгдэх болно шүү дээ.

Энэ мэт асуудлаар бид иргэдээ дэмжиж, ойлголт мэдээлэл өгөхийн төлөө ажиллаж байна. НДЕГ, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран ажил хэрэг болгосон санаачилгууд ч бий.

ХЧМЗ нийгмийн хамгааллын чиглэлээр өөр ямар ажлууд хийж байна вэ. Гаднын улс орнуудад буй манай консулын үйлчилгээ хэр хүртээмжтэй байдаг вэ?

Нийгмийн хамгааллын талаар бид багагүй ажил хийж ирсэн. ГХЯ-нд Хилийн чанад дахь иргэдэд туслах сан гэж байдаг. Энэхүү сан гадаадад буй иргэдэд нэн шаардлагатай өвчин эндэгдэл, эсвэл эх орон руугаа буцахад зардал мөнгө нь хүрэхгүй байгаа иргэдэд тусламж

үзүүлэх зорилготой. Сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээ бага. Гэхдээ 2026 оны төсөвт сууснаар бол сангийн хөрөнгийн хэмжээ 2-3 дахин нэмэгдсэн. Энэ сан манай зөвлөлтэй ямар нэг байдлаар хамааралгүй. Харин сангийн хөрөнгийг зөв зүйтэй зарцуулахад бид санаа оноогоо өгөөд явдаг.

Бид хилийн чанадад буй хэд хэдэн монгол иргэнд энэ сангаас тодорхой хэмжээний тусламж дэмжлэг үзүүлсэн. Энэ бүхэн ХЧМЗ-ийн дэргэдэх Нийгмийн бодлогын хорооны ажлууд л даа. Тухайлбал, Ковидын үеэр гадаадад гацсан 600 гаруй монгол иргэнээ дэмжиж, НҮБ-ын шилжилт хөдөлгөөний олон улсын аянуудтай хамтарч эх оронд нь буцаах ажлыг амжилттай зохион байгуулсан. ХЧМЗ нь төрийн бус байгууллага учир эдийн засаг, хөрөнгө санхүүгийн хувьд хомс. Тиймээс бүх зүйлд дэмжиж туслах боломжгүй ч зохион байгуулалтын талд боломжоороо ажиллахыг хүсдэг.

Хилийн чанадад буй монгол иргэдийн хувьд консулын үйлчилгээний хүртээмж асуудал болдог. Бид энэ талаар иргэдээсээ санал асуулга, судалгааг явуулдаг бөгөөд энэ жил дөрөв дэхээ явууллаа. Эндээс харахад, консулын үйлчилгээний соёл, хүртээмж харьцангуй нэмэгдсэн гэсэн дүн гарсан. ХЧМЗ-өөс багагүй хүчин чармайлт тавьсны дүнд консулын үйлчилгээ хүрч чаддаггүй, эсвэл огт байдаггүй газруудад ДТГ-ыг нээх, ажилтнуудын тоог нэмэх зэрэг санал тавьснаар бодит үр дүнд хүрсэн. Энэ бол төр, иргэн, ТББ-ын хамтын зүтгэл юм. Тухайлбал, АНУ-ын Чикаго хотод ДТГ нээсэн бол Ирланд улсын Дублин хотод ДТГ нээх асуудлыг ярьж байна.

Хилийн чанадад буй монголчууд маань гал түймэр, зуд турхан болоход хандив мөнгө өгдөг. Мөн эх орон руугаа шилжүүлж буй мөнгө дүн нь их өндөр тоо сонсогддог.

Манай зөвлөл сайн дурын олон ажлууд хийдэг. 2017 онд Монголд түймэр гарахад 72 сая төгрөгийн сайн дурын хандивыг ОБЕГ-т өгсөн. Ковидын үеэр “Эх орондоо маск хандивлая” аяныг өрнүүлснээр нэг сая гаруй маск, хамгаалалтын хувцсыг эрүүл мэндийн салбарт бэлэглэсэн.

Гадаадад буй иргэдийн шилжүүлдэг мөнгөн дүнг Монголбанк гаргадаг. Жилдээ 380-500 орчим сая ам.доллар орж ирдэг гэсэн тооцоо бий. Манай ХЧМЗ-ийн Удирдах зөвлөлд байдаг эдийн засагч эрдэмтний тооцоогоор бэлэн мөнгөнөөс гадна бараа бүтээгдэхүүний ►





► хэлбэрээр, хилээр бэлэн авч ордог мөнгөн дүнг тооцвол хоёр тэрбум ам.доллар Монголын эдийн засагт ордог гэсэн барагцаа тоо гарсан. 2023 онд Үндэсний статистикийн хорооноос хилийн чанад дахь иргэдийн дунд албан ёсны судалгаа явуулсан юм. Дээрх судалгааг НҮБ-ын дэргэдэх шилжилт хөдөлгөөний байгууллага (ИОМ)-тай хамтран ХЧМЗ-ийн дэмжлэгтэй хийж, 5000 орчим иргэн хамрагдсан. Судалгааны зарим хариултыг та бүхэнд сонирхуулъя. “Та эх орондоо буцаж очих уу” гэсэн асуултад 20 хувь нь “Очих бодолгүй байна” гэж хариулсан бол “Ойрын таван жилд эх орондоо очих бодол байна уу” гэхэд 40 хувь нь “үгүй” гэсэн байгаа юм. Энэ нь хилийн чанад дахь иргэддээ хандсан бодит бодлого бий болгох шаардлагатайг харуулж байгаа юм. Улсын баялаг нь хүн шүү дээ.

Гадаадад буй нэг иргэн 2023 оны статистик мэдээллээр жилд Монгол Улсын эдийн засагт 19 сая төгрөг оруулж байгаа юм. Үүнийг 12 сард хуваавал 1.5 сая орчим төгрөгийг нэг иргэн

сар бүр оруулж байна гэж бодвол Монгол Улсын нэг иргэний дундаж цалин, эсвэл хөдөлмөрийн хөлсний дундаж дүнг эх орондоо оруулаад байна. Тиймээс бид гадаадад буй нийт иргэн ийм хэмжээний мөнгийг Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа учраас эргээд хилийн чанадад буй иргэд рүүгээ хандсан төрийн бодлого хэрэгтэй байна гэж үзэж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор манай зөвлөлийн санаачилгаар УИХ-д Хилийн чанад дахь монголчуудыг дэмжих бүлэг байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Дэмжих бүлгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Д.Бум-Очир ажиллаж байна. Дэмжих бүлгийн хувьд хэд хэдэн асуудалд анхаарал хандуулж буй. Үүнд, хилийн чанад дахь иргэдийн сонгуульд цахимаар саналаа өгөх боломжийг судлах ажлын хэсэг байгуулах, хилийн чанад дахь иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих хууль эрх зүйн орчныг бий болгох бодлогын бичиг баримт боловсруулах зэрэг багтаж байна. ■